

4.2 Бага хурлууд

4.2.1 Нэгдүгээр бага хурал

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ ДАХЬ ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН СУДАЛГАА

НЭГДҮГЭЭР БАГА ХУРЛЫН ТАЙЛАН

2004 оны 12 дугаар сар

ГАРЧИГ

1	Танилцуулга	4-41
2	Бага хурлын зорилт, бүтэц зохион байгуулалт	4-42
3	Хатуу хог хаягдалд үнэлэлт дүгнэлт өгч тулгамдсан асуудлуудыг тодорхойлох	4-42
4	Тулгамдаж буй гол асуудлын учир шалтгаан ба үр нөлөөлийг тогтоож анализ хийх	4-43
5	Тулгамдаж буй гол асуудлуудыг шийдвэрлэхэд авах арга хэмжээг боловсруулах	4-49
6	Бага хуралд оролцогсдын үзэл бодол	4-55
7	Бага хурлын амжилтыг үнэлсэн үнэлгээ.....	4-55

БАГА ХУРЛЫН ТАЙЛАНД ТУСГАГДСАН ЗУРГУУД

Зураг 1	Учир шалтгаан ба үр нөлөөлийн модоор жишээлэн үзүүлсэн диаграм	4-44
Зураг 2	“А” Группын “Хууль бус хог хаягдлын цэг түүний байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл” сэдвээр хийсэн учир шалтгаан ба үр нөлөөлийн диаграм	4-45
Зураг 3	“В” Группын “Хог цуглуулах тээвэрлэх” сэдвээр хийсэн учир шалтгаан ба үр нөлөөлийн диаграм	4-46
Зураг 4	“С” Группын “Ландфил бүхий хогын нэгдсэн цэгийг байгуулах ” сэдвээр хийсэн учир шалтгаан ба үр нөлөөлийн диаграм.....	4-47
Зураг 5	“D” Группын “Гэр хорооллын гудамжнууд дахь хатуу хог хаягдал ” сэдвээр хийсэн учир шалтгаан ба үр нөлөөлийн диаграм	4-48
Зураг 6	“Зорилтын модны жишээ диаграм”	4-50
Зураг 7	Хууль бус хог хаягдлын цэгийг багасгах түүний байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах	4-51
Зураг 8	Хог хаягдлын цуглуулалт тээвэрлэлтийг сайжруулах	4-52
Зураг 9	Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөхүйц Ландфил байгуулах.....	4-53
Зураг 10	Цэвэр гэр хорооллын гудамжнууд.....	4-54
Зураг 11	Бүх шалгуураар нэгтгэн үнэлсэн бага хурлын явцын үнэлгээ	4-56

ХАВСРАЛТУУД

Хавсралт 1	Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг сайжруулах төслөөс зохион байгуулсан бага хуралд оролцогсдын нэрсийн жагсаалт	4-57
Хавсралт 2	Бага хурлын хөтөлбөр	4-59
Хавсралт 3	Бага хурлын нээлтийн үг	4-60
Хавсралт 4	Хатуу Хог Хаягдлын менежментэд гарч буй чухал асуудлууд	4-62
Хавсралт 5	Бага хуралд оролцогсдын үзэл бодол.....	4-65
Хавсралт 6	Бага хуралд оролцогсдын үнэлгээний хуудас	4-72
Хавсралт 7	Бага хурлын зургууд	4-74

1 Танилцуулга

Улаанбаатар хот да хь Хатуу Хог Хаягдлын Менежментийн судалгааны удиртгал тайланд бага хурлын тоймд төлөвлөн тусгасны дагуу 2004 оны 12-р сарын 9, 10-ны өдрүүдэд Пүрэв Баасан гаригуудын өглөө уг судалгааны анхны бага хурлыг Улаанбаатар зочид буудалд зохион байгуулав.

Уг бага хуралд оролцох гишүүдийн талаар Улаанбаатар Хотын Захирагчын Ажлын Албаны Хот Тохижолтын хэлтсийн мэргэжилтэн Бадамын Дэлгэрбаяртай хэлэлцэн тохиролцож нилээд хэдэн салбраас 50 мэргэжилтэн, уг судалгаатай холбоотой байгууллагын төлөөлөгчдийг урьж оролцуулахаар болсон ба үүнд яамдын төлөөлөгчид хотын болон дүүргийн албаныхан болон тохижолт үйлчилгээний компаныхан мөн төрийн бус байгууллагуудын төлөөлөгчид оролцсон болно.

Хавсралт 1: Тус бага хуралд уригдан оролцсон гишүүдийн нэрсийн жагсаалтыг хавсаргав.

Хавсралт 2: Бага хурлын хөтөлбөрийг оруулав.

Бага хурлын анхны өдөр ЖАЙКА-ийн болон ЖАЙКА-ийн зөвлөх хорооны гишүүдээс бүрдсэн хэд хэдэн төлөөлөгчид оролцлоо. Үүнд:

- ноён. Ёошио Канзаки /ЖАЙКА-ийн Монгол дахь суурин төлөөлөгч
- ноён. Ота Масааки /ЖАЙКА-ийн Монгол дахь суурин төлөөлөгчийн туслах
- хадагтай. Алгаагийн Сайхантуяа /Монгол дахь ЖАЙКА-ийн хөтөлбөрийн мэргэжилтэн
- ноён. Китаваки Хидитоши /Японы Тоёо Их Сургуулийн профессор Бүс нутгийн хөгжлийн судалгааны тэнхимийн эрхлэгч, ЖАЙКА-ийн Зөвлөх Хорооны дарга
- ноён. Нагасэ Ютака / ЖАЙКА-ийн Зөвлөх Хорооны гишүүн, Саппоро хотын Байгаль Орчны хэрэг эрхлэх товчооны бохир усны менежментийн хэсгийн Хог Хаягдлын менежментийн хэлтсийн дарга
- ноён .Мурата Такуяа /ЖАЙКА-ийн төв оффиссын Дэлхийн Байгаль Орчны хэлтсийн Байгаль Орчны Менежментийн 2-р багийн мэргэжилтэн

Хавсралт 3: Улаанбаатар Хотын Захирагчын Ажлын Албыг төлөөлөж Улаанбаатар хотын Ерөнхий Менежер Г.Мөнхбаярын тус бага хурлыг нээж хэлсэн үг, ЖАЙКА-г төлөөлж ЖАЙКА-ийн Монгол дахь суурин төлөөлөгч ноён Ёошио Канзакигийн хэлсэн үгийг тус тус оруулав.

Дээрх төлөөлөгчид тус бага хурлыг нээж үг хэлсний дараа ЖАЙКА-ийн судалгааны багийн удирдагч ноён Сүсүмү Шимура Монгол Улсын Улаанбаатар хотын “Хатуу хог Хаягдлын Менежментийн судалгааны тоймыг” паверпойнт программ дээр үзүүлж судалгааны танилцуулга хийсэн бөгөөд судалгааны танилцуулгын материалыг бага хуралд

2 Бага хурлын зорилт, бүтэц зохион байгуулалт

- тус бага хурлын зорилтууд нь хатуу хог хаягдалд холбоотой асуудлуудыг хэлэлцэж, туршлага солилцох
- тус салбарын бусад хэсэгт гарч буй асуудлуудын уялдаа холбоог сайжруулах
- мөн Улаанбаатар Хотын Хатуу Хог Хаягдлын Менежментийн судалгааны хамтын ажиллагааг сайжруулахын тулд харилцан зөвшилцөх замыг бий болгох явцыг эхлүүлэх

Тус бага хурлын бүтэц зохион байгуулалтыг судалгааны багийн гишүүн Кейко Кани төслийн шаталсан менежмент болон логик арга зүй дээр үндэслэн, бага хурлын нөхцөлд тохирсон бүтэц зохион байгуулалтыг боловсруулсан бөгөөд бага хурлын явцад дараах 3 үе шатууд голлон явагдсан болно.

Үүнд: а. Хатуу Хог Хаягдалд үнэлэлт дүгнэлт өгч тулгамдсан гол асуудлуудыг тодорхойлох (уг асуудлыг бага хурлын хөтөлбөрийн эхний өдрийн 4-р зүйлд тусгаж ярилцсан)

б. Тулгамдсан асуудлуудын учир шалтгаан ба үр нөлөөлийг тогтоож анализ хийх (бага хурлын хөтөлбөрийн эхний өдрийн 5-р зүйлд тусгаж ярилцсан)

в. Эдгээр асуудлуудыг шийдвэрлэхэд шаардлагатай авах арга хэмжээг боловсруулах (бага хурлын хөтөлбөрийн хоёр дахь өдрийн 3-р зүйлд тусгаж ярилцсан). Үүний дараа бага хурлын хамгийн чухал үе шат болох бага хуралд оролцож буй байгууллага, компани, яамдын төлөөлөгчид, иргэний болоод байгууллагын төлөөлөгчдийн зүгээс Хатуу Хог Хаягдлын Менежментийн судалгаанд цаашид өөрсдийн оруулах хувь нэмрийнхээ хувьд буюу төслийн судалгааны ажилд зориулж өөрсдийн санал, үзэл бодлоо илэрхийлэв. (Бага хурлын хөтөлбөрийн хоёр дахь өдрийн 4-р зүйлд тусгаж ярилцав)

Бага хурлын ихэнх ажлуудыг группууд хоорондоо хэлэлцэж хийсэн бөгөөд тус бага хуралд оролцогсдыг нийт 4 баг болгож хуваасан ба Хавсралт 1.д үзүүлэв.

Группын бүтцийн хувьд багийн гишүүдийг өөр өөр байгууллагуудын төлөөлөгчдөөр бүрдүүлсэн бөгөөд ингэснээр зөвхөн өөрийн байгууллагын үзэл бодолд хязгаарлагдахгүйгээр багийн гишүүд асуудлыг олон талаас нь авч хэлэлцэх ач холбогдолтой байсан юм.

3 Хатуу хог хаягдалд үнэлэлт дүгнэлт өгч тулгамдсан асуудлуудыг тодорхойлох

Бага хуралд оролцогсдын хамгийн эхний хийх ёстой зүйл бол хатуу хог хаягдлын менежментэд гарч буй тулгамдсан чухал асуудлуудын жагсаалтыг гаргах даалгавар байсан. Хамгийн чухал тулгамдсан асуудлуудыг олоход багуудын зарим санаа давхцаж байсан үүнийг Хавсралт 4-д үзүүлэв.


Багийн гишүүдийн дэвшүүлсэн тулгамдсан асуудлуудаас хатуу хог хаягдлын менежментийн хувьд тулгамдаад байгаа доорх 4 чухал асуудлуудыг багийн гишүүдтэй цаашид ярилцахаар сонгож авсан юм. Үүнд:

- Гэр хороололын гудамжнууд дахь хатуу хог хаягдал
- Хууль бус хог хаягдлын цэг түүний байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл


- Хог цуглуулах тээвэрлэх систем хангалтгүй
- Хогийн нэгдсэн цэг хангалтгүй

4 Тулгамдаж буй гол асуудлын учир шалтгаан ба үр нөлөөлийг тогтоож анализ хийх


Гэр хороолол дахь хатуу хог хаягдлын учир шалтгаан ба үр нөлөөлийн “мод”-оор жишээлэн үзүүлсэн диаграмыг Зураг 1-д үзүүлэв. Бага хурлыг зохион байгуулахаас өмнө судалгааны багийнхан бага хуралд оролцогсдод ойлгомжтой болгохын тулд өөрсдийн сонгож авсан тулгамдсан асуудлуудыг хэрхэн тодорхойлох талаар жишээ болгон учир шалтгаан ба үр нөлөөлийн мод-оор жишээлэн үзүүлсэн диаграмыг бэлтгэсэн. Бага хурал дээр тулгамдсан асуудлуудыг тодорхойлоход нэг асуудал давхцаж гарч ирсэн ба тулгамдаад байгаа асуудлуудын ул үндсийг судлаж үзэхэд тус салбарын үр бүтээмж дутагдалтай хэсэгт тодорхойлогдож гарч ирсэн асуудлууд асуудлуудын үр дагаврыг бий болгож байгаа бөгөөд энэ нь улмаар үндэсний нөлөөлөлд үүсэх асуудлыг тодорхойлож байсан юм. Тус бага хуралд оролцсон 4 багуудийн хийсэн учир шалтгаан ба үр нөлөөлийн диаграмыг Зураг 2, 3, 4, 5.д үзүүлэв. Бага хурлын туршид багууд өөрсдийн хийсэн диаграмыг үзүүлж үр дүнг ярилцсан.




Зураг 1 Учир шалтгаан ба үр нөлөөлийн модоор жишээлэн үзүүлсэн диаграм




Зураг 2 “А” Группын “Хууль бус хог хаягдлын цэг түүний байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл” сэдвээр хийсэн учир шалтгаан ба үр нөлөөлийн диаграм



Зураг 3 “В” Группын “Хог цуглуулах тээвэрлэх” сэдвээр хийсэн учир шалтгаан ба үр нөлөөлийн диаграм



Зураг 4 “С” Группын “Ландфил бүхий хогын нэгдсэн цэгийг байгуулах” сэдвээр хийсэн учир шалтгаан ба үр нөлөөлийн диаграм




Зураг 5 “D” Группын “Гэр хорооллын гудамжнууд дахь хатуу хог хаягдал” сэдвээр хийсэн учир шалтгаан ба үр нөлөөлийн диаграм

5 Тулгамдаж буй гол асуудлуудыг шийдвэрлэхэд авах арга хэмжээг боловсруулах

Бага хурлын хоёр дахь үе шат нь тулгамдаад байгаа гол асуудлуудыг шийдэхийн тулд ямар зорилтуудыг тавьж болох тухай байсан ба уг зорилтонд хүрэхийн тулд асуудлуудыг аль болохоор дэлгэрэнгүй тодорхойлож, ямар арга хэмжээ авах шаардлагатай ба гарч болох үр нөлөөлүүдийг тодорхойлох ёстой байв. Эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд авч явуулах ёстой арга хэмжээ нь системийн бүтцийн, бодлогын, хууль эрх зүйн, санхүү эдийн засгийн болон өөр төрлийн байж болох ба бага хуралд оролцогсдыг зорилтоо тодорхойлохын тулд аль болохоор дэлгэрэнгүй тодорхой асуудлууд дэвшүүлэхийг хүссэн юм. Зорилтонд хүрэхийн тулд авч явуулах арга хэмжээ нь хэд хэдэн сонголт хувилбартай байж болох бөгөөд багуудийн дэвшүүлсэн санаа болон зөвлөгөөг Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийн судалгаанд чухал асуудал болгон оруулах ёстой байв.


Учир шалтгаан ба үр нөлөөлийн хийсэн диаграммын гол асуудлуудыг сонгож аваад зорилтын модны диаграм хийлгэж сайжирсан салбарын үр бүтээмж, байгууллагууд ба бодлогуудын явуулж буй үйл ажиллагаа, гарч буй дагваруудаас үүсэх нөлөөлөл болон энэ нь цаашид үндэсний нөлөөлөлд хүрэх хүртэл тодорхойлсон диаграммыг Зураг 6.д зорилтын модны жишээ диаграммаар үзүүлэв.

Бага хуралд оролцогсдод тулгамдаад байгаа асуудлын учир шалтгаан ба үр нөлөөллийг тодорхойлсны дараагаар өөрсдийн сонгож авсан гол асуудлууд дээр зорилтыг хэрхэн тодорхойлох вэ мөн ямар арга хэмжээ авч явуулах ёстойг ойлгомжтой болгох үүднээс судалгааны багийнхан бага хурал болохоос өмнө Зорилтын модны жишээ диаграммыг хийж боловсруулсан юм. Зураг 7,8,9,10.д 4 багуудийн хийсэн зорилтын модны диаграммыг үзүүлэв. Багууд өөрсдийн хийсэн зорилтын модны диаграммыг баг тус бүрээр нийт оролцогсдод үзүүлж танилцуулав.




Зураг 6 “Зорилтын модны жишээ диаграм”

А Групп




Групп В




Зураг 8 Хог хаягдлын цуглуулалт тээвэрлэлтийг сайжруулах

Групп “С”



Зураг 9 Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөхүйц Ландфилл байгуулах

Групп "D"



Зураг 10 Цэвэр гэр хорооллын гудамжууд

6 Бага хуралд оролцогсдын үзэл бодол

Бага хуралд оролцогсод уг бага хурлыг нилээд үнэлж, сайшаалтай ажил хийгдэж байгааг илэрхийлээд Хатуу Хог Хаягдлын менежментийн судалгааны талаар оролцогсод өөрсдийн байгууллагыг төлөөлөж буй болоод иргэний зүгээс үзэл бодлоо илэрхийлж уг хатуу хог хаягдлын менежментийн судалгаанд гүйцэтгэх тэдний цаашдын үүрэг роль болон судалгааны талаар дэвшүүлж буй санаа, зөвлөлгөөний талаар ярилцав. Тус бага хуралд оролцогсод өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх хэсгийг Улаанбаатар хотын Захирагчын Ажлын Албаны хот тохижолтын хэлтсийн мэргэжилтэн Б. Дэлгэрбаяр удирдан явуулсан. Хавсралт 5.д бага хуралд оролцогсдын үзэл бодлыг оруулав.

7 Бага хурлын амжилтыг үнэлсэн үнэлгээ

Бага хуралд оролцогсод тарааж өгсөн хурлын талаарх үнэлгээний хуудсыг дүгнэж Хавсралт 6.д үзүүлэв. Тус бага хуралд оролцсон 24 хүн бага хурлын үнэлгээний хуудсыг 1 буюу “муу” гэсэн үнэлгээнээс 5 буюу “онц” хүртэл үнэлгээгээр үнэлж доорхи 4 шалгуур үзүүлэлтэд өөрсдийн үнэлгээг өгч бөглөсөн юм.

А. Тус бага хурал таньд хэрэг болсон уу?

Б. Бага хурал асуудлын талаарх нийтлэг ойлголтыг дээшлүүлж хамтын ажиллагааны хэрэгцээг таньд ойлгуулсан гэж үзэж байна уу ?

В. Бага хурлын үйл явц үр ашигтай бөгөөд сонирхолтой байсан гэж үзэж байна уу?

Г. Бага хурлын ерөнхий амжилтыг та хэр зэрэг байсан гэж үзэж байна?

Оролцогсдын үнэлсэн үнэлгээнээс үзэхэд дундаж буюу 3 гэсэн үзүүлэлтээс доош үнэлсэн оноо байсангүй ихэнх нь маш сайн гэсэн үнэлгээ байсан ба бүх шалгуураар буюу доорх 4 асуултанд хариулсан үнэлгээг задалж үзвэл:

А асуултанд Онц гэж дүгнэсэн 58%

Б асуултанд Онц гэж дүгнэсэн 71 %

В асуултанд Онц гэж дүгнэсэн 67 %

Г асуултанд Онц гэж дүгнэсэн 63 % тус тус байлаа.

Нийт үнэлгээний дундаж нь дээд үзүүлэлт 5 балл байхаас (4.5-4.6 балл) буюу асуулт тус бүр дээр 91%, 93%, 92% ба 91% тус тус байлаа.

Дөрвөн шалгуураар үнэлсэн үнэлгээний нэгдсэн дүнг Зураг 11.д үзүүлэв.



Зураг 11 Бүх шалгуураар нэгтгэн үнэлсэн бага хурлын явцын үнэлгээ

**Хавсралт 1 Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг сайжруулах
төслөөс зохион байгуулсан бага хуралд оролцогсдын нэрсийн жагсаалт**

№	Байгууллага	Албан тушаал	Нэр	Групп	
1	Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар	Нийслэлийн засаг даргын орлогч	Б. Баатарзориг		
2	Улаанбаатар Хотын Захирагчын Ажлын Алба	Ерөнхий менежер	Г.Мөнхбаяр		
3	Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар	Хот байгуулалт, стратеги бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга	Ч.Бат	A	
4		Хот байгуулалт, стратеги бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн	Ч. Батсайхан	B	
5	Улаанбаатар хотын Захирагчын Ажлын Алба	Хот тохижилтын хэлтсийн дарга	Ц.Болд	C	
6		Хот тохижилтын хэлтсийн мэргэжилтэн	Л.Баатарцогт	D	
7		Хот тохижилтын хэлтсийн мэргэжилтэн	Б. Дэлгэрбаяр	A	
8		Хот тохижилтын хэлтсийн мэргэжилтэн	Ч. Бадамханд	B	
9		Хот тохижилтын хэлтсийн мэргэжилтэн	П. Энхтуяа	C	
10		Хот тохижилтын хэлтсийн мэргэжилтэн	Т. Буянжаргал	D	
11		Байгаль Орчны Яам	Тогтвортой хөгжил, хүрээлэн буй орчны газрын дарга	А.Намхай	A
12			Тогтвортой хөгжил, хүрээлэн буй орчны газрын орлогч дарга	Б.Баясгалан	B
13	Тогтвортой хөгжил, хүрээлэн буй орчны мэргэжилтэн		М. Золжаргал	C	
14	Тогтвортой хөгжил, хүрээлэн буй орчны мэргэжилтэн		С.Эрдэнэцэцэг	D	
15	Хамтын ажиллагааны хэлтсийн дарга		Н.Оюундарь	A	
16	Хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн		Д.Эрдэнэбулган	B	
17	Үйлдвэр Худалдааны Яам	Үйлдвэрийн бодлого зохицуулалтын газрын дарга	Бадарч	C	
18		Үйлдвэрийн бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн	Б.Баясгалан	D	
19	Эрүүл Мэндийн Яам	Бодлого зохицуулалтын газрын орчны нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Энхцэцэг	A	
20	Нийслэлийн Байгаль Орчны Газар	Нийслэлийн Байгаль Орчны Газрын дарга	Г.Бүдрагчаа	B	
21	Нийслэлийн Хот Төлөвлөлт, Эрдэм шинжилгээ зураг төслийн хүрээлэн	Нийслэлийн Хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэнгийн захирал	Г.Болд	C	
22	Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Газар	Байгаль орчин, дэд бүтцийн хяналтын хэлтсийн дарга	Ц.Цэнгэл	D	
23		Байгаль орчин, дэд бүтцийн хяналтын хэлтсийн улсын байцаагч	Н.Оюунцэцэг	A	
24		Нийгэм, эрүүл мэндийн хэлтсийн дарга	Л.Бямбасүрэн	B	
25		Нийгэм, эрүүл мэндийн хяналтын хэлтсийн улсын байцаагч	Н.Оюун	C	
26		Төв лабораторын эрхлэгч	С.Бумаа	D	
27	Нийслэлийн Орон Сууц нийтийн аж ахуй газар	Нийслэлийн Орон Сууц нийтийн аж ахуйн газрын дарга	н. Мөнхцог	A	
28	Баянзүрх дүүргийн Засаг Даргын Тамгын Газар	Тохижилт үйлдвэрлэл үйлчилгээний хэлтсийн дарга	Б. Наранмөнх	B	
29	Баянгол дүүргийн Засаг Даргын Тамгын Газар	Тохижилт үйлдвэрлэл үйлчилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн	Д.Гэндэнпунцаг	C	
30	Сүхбаатар дүүргийн Засаг Даргын Тамгын Газар	Тохижилт үйлдвэрлэл үйлчилгээний хэлтсийн дарга	Г. Оюунцэцэг	D	
31	Согинохайрхан дүүргийн Засаг Даргын Тамгын Газар	Тохижилт үйлдвэрлэл үйлчилгээний хэлтсийн дарга	Ж.Жамбалдорж	A	
32	Хан уул дүүргийн Засаг Даргын Тамгын Газар	Тохижилт үйлдвэрлэл үйлчилгээний хэлтсийн дарга	Ч. Оюунбаатар	B	
33	Чингэлтэй дүүргийн Засаг Даргын Тамгын Газар	Тохижилт үйлдвэрлэл үйлчилгээний хэлтсийн дарга	Д. Оюунтуяа	C	
34	Налайх дүүргийн Засаг Даргын Тамгын Газар	Тохижилт үйлдвэрлэл үйлчилгээний хэлтсийн дарга	М.Баатарцогт	D	

35	Багахангай дүүргийн Засаг Даргын Тамгын Газар	Тохижилт үйлдвэрлэл хэлтсийн дарга	Д. Баатархүү	A
36	Багануур дүүргийн Засаг Даргын Тамгын Газар	Тохижилт үйлдвэрлэл хэлтсийн дарга	Б.Эрдэнэчимэг	B
37	Нөөц Нийслэлийн өмчит үйлдвэрийн газар	Захирал	Б. Наран	C
38	Баянзүрх дүүргийн тохижилт үйлчилгээний компани	Захирал	Ц. Цогтсайхан	D
39	Баянгол дүүргийн тохижилт үйлчилгээний компани	Захирал	Д. Батсайхан	A
40	Сүхбаатар дүүргийн тохижилт үйлчилгээний компани	Захирал	Ц. Баттүвшин	B
41	Сонгинохайрхан дүүргийн тохижилт үйлчилгээний компани	Захирал	Р. Дондов	C
42	Хан уул дүүргийн тохижилт үйлчилгээний компани	Захирал	П. Ганбаатар	D
43	Чингэлтэй дүүргийн тохижилт үйлчилгээний компани	Захирал	Ч.Энхболд	A
44	Налайх дүүргийн тохижилт үйлчилгээний компани	Захирал	З. Эрдэнэхүү	B
45	Багануур дүүргийн тохижилт үйлчилгээний компани	Захирал	Б. Бямбадорж	C
46	“Байгаль Эрдэнэ сан” төрийн бус байгууллага	Тэргүүн	н. Сономпил	D
47	“WWF”	Мэргэжилтэн	Л. Долгормаа	A
48	“Туул 21” ТТБ	Тэргүүн	Д. Гантигмаа	B
49	“Ариун орчин” төрийн бус байгууллага	Тэргүүн	Г.Цэцэгмаа	C
50	Иргэдийн төлөөлөгч	иргэн	н. Эрдэнэбаатар	D

Хавсралт 2 Бага хурлын хөтөлбөр

- Эхний өдөр

2004 оны 12 сарын 9 (Пүрэв гариг)		
Авч явуулах арга хэмжээ	Байгууллага	Цаг
1. Монгол талаас бага хурлыг нээж үг хэлнэ	Улаанбаатар хотын Захирагчын Ажлын Алба	9.00
2. Японы талаас бага хурлыг нээж үг хэлнэ	ЖАЙКА	9.10
3. Судалгааны болоод бага хурлын талаар товч тайлбар хийнэ	Судалгааны Баг	9.20
4а. Хатуу Хог Хаягдлын менежментийн судалгаанаас өгсөн даалгаврыг хийж гүйцэтгэх	Бүх байгууллагаас оролцож буй 4 багийн гишүүдийн ярилцлага	9.45
Цай		10.30
4б. Үргэлжлэл	Чухал асуудлуудын талаар багууд тайлагнана	10.45
4в. Дөрвөн гол асуудлуудыг нийтэд нь хэлэлцэнэ	Судалгааны Баг	11.15
5а. Уир шалтгааны нөлөөлийн анализ	Судалгааны багийн танилцуулга оролцогч багууд	11.30
5б. Үргэлжлэл	Багийн тайлан	12.00
6. Үр дүнгийн тойм	Судалгааны Баг	12.30
Өдрийн хоол		13.00

- Бага хурлын хоёр дахь өдөр

2004 оны 12 сарын 10 (Баасан гариг)		
Авч явуулах арга хэмжээ	Байгууллага	Цаг
1. Бага хурлын талаарх тайлбар	Судалгааны баг	9.00
2. Учир шалтгаан/нөлөөлийн "модыг" дуусгах	Судалгааны баг, оролцогч багуудын хариу	9.15
3а. Асуудлуудыг шийдвэрлэхийн тулд зорилтын "мод"-ыг бий болгох	Судалгааны багийн танилцуулга Оролцогч багууд	10.00
Цай		10.30
3б. Үргэлжлэл	Багууд тайлагнана	10.45
4. Байгууллагын гүйцэтгэх үүргүүд	Багийн гишүүд өөрсдийн үүргээ дээшлүүлэхэд шардлагатай зүйлсийг мэдэгдэж тайлагнана	11.15
5. Ажлын цар хүрээний тойм	Судалгааны Баг	12.00
6. Бага хуралд өгөх үнэлгээ	Оролцогсод	12.15
7. Үүнд хамаатай бүхий л байгууллагуудын үүрэг хариуцлагыг тодорхойлон шийдвэрт хүрэх	Судалгааны Баг	12.30
Өдрийн хоол		13.00

Хавсралт 3 Бага хурлын нээлтийн үг

А.3.1 Улаанбаатар хотын Хог Хаягдлын менежментийг сайжруулах мастер төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд зохион байгуулаж байгаа бага хуралд Улаанбаатар хотын Ерөнхий Менежер Г. Мөнхбаярын хэлсэн үг

2004 оны 12 сарын 9

Эрхэм хүндэт ноёд, хадагтай та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая

Япон улсын засгийн газраас санхүүжүүлэн хэрэгжүүлж буй Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох мастер төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгээс зохион байгуулж байгаа бага хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид, нийслэлийн засаг дарга болон хувиасаа талархаж байгаагаа илэрхийлье.

Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг сайжруулах мастер төлөвлөгөөг Япон улсын засгийн газар, ЖАЙКА байгууллагатай хамтран 16 сарын дотор боловсруулах бөгөөд энэ ажлын хүрээнд хог хаягдлын бүтэц, хэмжээ, шинж чанарыг тодорхойлох, хог хаягдлыг цуглуулалт, тээвэрлэлтийн өнөөгийн байдал, хог хаягдлын төлбөрийн хэмжээг оновчтой тогтоох, хог хаягдлыг дарж булах үйл ажиллагааг боловсронгуй болгох, хүний нөөцийн чадамжийг дээшлүүлэх, хог хаягдлын хэтийн хэмжээ, бүрдлийн прогноз гаргах, хог хаягдлын цэгийг тогтоох, өөрчлөн шинэчлэх үйл ажиллагаатай холбоотой судалгааг хийх бөгөөд туршилтын төслүүдийг эхлүүлэх юм.

Энэхүү төслийг хэрэгжүүлэхэд Удирдах зөвлөл, Техникийн ажлын хэсэг, Судалгааны баг тус тус байгуулагдсан бөгөөд энэ ажлыг хэрэгжүүлэх, цаг хугацаанд нь гүйцэтгэхэд байгаль орчин, хог хаягдлын чиглэлээр ажилладаг төр захиргааны бүх байгууллагууд оролцохоос гадна, олон нийтийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг өргөнөөр татан оролцуулах болно.

Дээр дурдсан ажлын хэсэгт орсон ихэнх хүмүүс энэхүү бага хуралд оролцож байгаа бөгөөд энэхүү төслийг амжилттай хэрэгжүүлэхэд та бүхний оролцоо, дэмжлэг ихээхэн хувь нэмэр оруулна гэдэгт эргэлзэхгүй байна.

Улаанбаатар хотын хог хаягдлын өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, тулгамдаж байгаа асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх, боломжит хувилбаруудыг тодорхойлох, хог хаягдлын менежменттэй холбоотой ажилладаг байгууллагуудыг нэгдсэн ойлголт, зөвшилцөлд хүрэх зорилгоор өнөөдрийн бага хурлыг зохион байгуулж байгаа юм.

Энэхүү бага хуралдуригдан оролцож байгаа та бүхэн идэвхи, санаачлагатай оролцоно гэдэгт найдаж байгаа бөгөөд хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

А.3.2 Японы талаас бага хурлыг нээж ЖАЙКА-г төлөөлөн Монгол дахь суурин төлөөлөгч ноён Ёошио Канзакигийн хэлсэн үг

Өглөөний мэнд ноёд хатагтай нараа!

Би Жайка-г төлөөлөн та бүгдэд мэндчилж байна.

Нэн түрүүнд, энэ сараас эхэлээд бид Монгол улсын Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийн судалгааг Улаанбаатар хотын Засаг Даргын Тамгын Газрын (ЗДТГ) холбогдох байгууллагуудтай хамтарч хийх бололцоотой болсонд би маш баяртай байгаагаа хэлээ. ЗДТГ-ын хийсэн бэлтгэл ажилд, тэр дундаа судалгааг хөтлөн явуулах хамтран ажиллагч талуудыг зохион байгуулсан болон судалгааны багийн судалгааг саадгүй хийлгэхийн тулд офисын бэлтгэл ажлыг хийсэнд би бас талархаж байна.

Жайка нь Улаанбаатар хотын ЗДТГ болон Байгаль Орчны Яам хоорондын хамтын ажиллагааны сайн амжилтыг тэсэн ядан хүлээхээс гадна ЗДТГ-ын хог хаягдлын асуудлыг шийдвэрлэх тал дээр гаргаж буй Яамдтай хамтарч хогийн төвлөрсөн цэг байгуулах боломжит газруудыг тогтоох ажлын хэсэг байгуулах ба хог цуглуулгын үйлчилгээний төлбөр хураах системийг сайжруулах гэх мэт чин сэтгэлийн хандлагад талархлаа илэлрийлж байна.

Жайка Монголын хөгжил дэвшлийг олон тал дээр дэмжиж ирсэн хэдий ч хатуу хог хаягдлын менежментийн салбарт анх удаагаа дэмжлэг үзүүлж байна. Жайка-гийн холбогдох салбарууд дээрх туршлагын тухайд гэвэл энэ маягийн хамтын ажиллагаа олон орнуудад хийж байсан ба хатуу хог хаягдлын менежментийн асуудлууд нь тэдгээр орнууд ба хотуудын оршин суугчдын амьдарч буй орчинтой холбоотой гэдгийг мэдэж авсан. Хатуу хог хаягдлын менежментийн асуудлууд нь тухайн газрын оршин суугчдын амьдралын хэв маягийг ойлгохгүйгээр шийдэгдэхгүй. Иймээс Улаанбаатар хот дахь Хатуу хог хаягдлын хэмжээнд гарч байгаа асуудлуудыг уг бага хурлаар та бүхэн хэлэлцэн ярилцаж тодорхойлох явдал нь тус судалгааны эцсийн зорилго болох бодит Мастер төлөвлөгөөг боловсруулахад нэн чухал ач холбогдолтой билээ.

Энэхүү бага хурлын зорилго нь Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментэд гарч байгаа асуудлуудыг хэлэлцснээр Улаанбаатар хотын захиргаа үүнд ямар арга хэмжээ авах ёстой болон уг судалгааг хэрхэн хэрэгжүүлэх талаар хамтын зөвшилцөлд хүрэх явдал юм. Тус бага хурлыг 2 өдөр үргэлжилэхэд хурлын явцад та бүхэн өөрсдийн үзэл бодлыг илэн далангүй илэрхийлж тус судалгаанд хувь нэмэр оруулахуйц өөрсдийн зөвлөгөөг өгнө гэдэгт бид итгэлтэй байна.

Миний хажууд баруун / зүүн гарт сууж байгаа хүн бол ЖАЙКА-ийн Зөвлөх Хорооны дарга ноён Хидитоши Китаваки харин миний баруун/ зүүн талд сууж байгаа хүн бол судалгааны багийн удирдагч ноён Сүсүмү Шимура юм.

Ингээд, Судалгааны багийн удирдагч ноён Сүсүмү Шимураг судалгааны дэлгэрэнгүй тайлбар хийлгэхээр хуралд оролцож буй та бүхний өмнө урья.

Хавсралт 4 Хатуу Хог Хаягдлын менежментэд гарч буй чухал асуудлууд

Хатуу хог хаягдалд гарч буй чухал асуудлуудыг багууд доорх байдлаар тодорхойлов.

А Групп

1. Хогийг ил задгай хаядаг
2. Хог хаягдал нилээд газарт хаягдаж байна
3. Хөрс бохирдуулж байна
4. Хог хаягдлыг шатааж агаар бохирдуулж байна
5. Цэвэр ус болон гүний усыг бохирдуулж байна
6. Хогийг эхэн үед нь ангилан ялгалт хийдэггүйгээс хогийн хэмжээ ихэсч байна
7. Ил задгай хаясан хогийг хүн амьтан идэж байна энэ нь халдварт өвчин тархах явдлыг үүсгэнэ
8. Хорхой шавьж, хортон мэрэгчдийг үржих орчин бий болгож өгч байна
9. Хог хаягдал салхинд хийсч орчин бохирдуулж байна
10. Хог хаягдлыг тээвэрлэдэг машин механизм дутагдалтай
11. Оршин суугчид, иргэд хог хаягдлын талаарх мэдлэг муу
12. Хог хаягдлын төлбөр бүрэн хийгддэггүй
13. Хог хаягдлын тухай мэдлэг хууль дүрэм муу хог хаягдлын талаарх хуулийн хэрэгжилт муу
14. Хог хаягдлын талаарх олон нийтийн сурталчилгаа, мэдлэг мэдээлэл хангалтгүй
15. Мэргэжлийн бус хог хаягдлыг тээвэрлэдэг компаниуд хог хаягдлыг зөвшөөрөлгүй буюу хууль бус хог хаягдлын цэг дээр хаядаг учраас хууль бус хог хаягдлын цэгийг ихэсгэж байна
16. Ахуйн хог хаягдлыг аюултай хог хаягдалтай нийлүүлж хаядаг явдал нь ард иргэдэд эрүүл ахуйн болоод эрүүл мэндийн эрсдлүүдийг бий болгож байна
17. Үерийн усны суваг шуудууруу хог хаягдлыг хаяж үерийн усны шуудууг бөглөж байна
18. Гудамжнууд дахь хогны сав бага байдаг хангалтгүй
19. Цэцэрлэг болон сургуулиудад хог хаягдлын талаар анхан шатны мэдлэг өгч, хичээл заадаггүй
20. Хог цуглуулах тогтсон цагийн хуваарь байдаггүйгээс хүмүүс хогоо дуртаа үедээ хаядаг
21. Хэн хаана үйлдвэрийн хортой хог хаягдлыг хаях нь мэдэгддэггүйгээс байгууллагууд аюултай хатуу болон шингэн хог хаягдлыг дуртай газраа хаядгаас болж байгаль орчны бохирдол үүсч байна
22. Гэр хорооллын айлуудад бохирын систем байдаггүйгээс айлууд хашаандаа өөрсдийн жорлон хийдэг ба жорлонгийн бохир дүүрсэн үед хөлдсөн бохирыг ахуйн хог хаягдалтай цуг хаядаг
23. Аюултай хог хаягдлын талаар хүмүүс мэдлэг багатай
24. Орон сууцны хог хаягдлын бункерээс муухай үнэр гардаг
25. Дахин боловсруулах, дахин ашиглах г.м **3 R- ийн** системийг хэрэгжүүлж сураагүй
26. Хог хаягдлын менежментийн талаар гарын авлага, ном товхимол хангалтгүй
27. Хог хаягдлын бүрдэл, хэмжээ, чанарын талаарх мэдээлэл дутмагаас Улаанбаатар хот дахь хог хаягдлын бүрдэл, хэмжээ чанарын талаар ямар хэмжээтэй байгаа нь мэдэгдэхгүй байна

В Групп

1. Хууль эрх зүйн систем үйлчилдэггүй
2. Хог хаягдлыг цагт нь авдаггүй
 - а. Хог ачиж цуглуулдаг машин техникийн засвар үйлчилгээ муу байнга шинэчилдэггүй
 - б. Амьжиргааны төшин дорой учраас хогийн төлбөр төлөх чадвар муу
3. Хог хаягдлыг ачиж цуглуулдаг тогтсон цагийн хувааргүйгээс болж ил задгай хог хаях явдлыг ихэсгэж энэ нь улмаар хүний эрүүл мэндэд эрсдэл учруулж байна.
4. Хог хаягдлын тухай сургалт сурталчилгаа хангалтгүйгээс байгаль орчин бохирдож байгаа талаар мэдлэг тун бага
5. Хог хаягдлыг ангилан ялгадаггүй хог хаягдлыг дахин ашиглаж болвсруулдаггүй
6. Аюултай хог хаягдал болох аккумулятор болон машины тос зэргийг дахин ашиглах, боловсруулах механизм байдаггүй
7. Үйлдвэрийн хортой хог хаягдал болох хүнд металлууд жишээ нь хромыг бүрэн дарж булж хаядаггүй ийм төрлийн хог хаягдлыг яаж хаях ёстой механизм тогтоогүй
8. Эмнэлгийн ба химийн хортой хог хаягдлыг хаях цэг байхгүйгээс ард иргэдийн эрүүл мэнд болон байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байна
9. Гялгар уутыг маш ихээр хэрэглэж байна энэ нь байгальд болоод хөрсөнд шингэдэггүй хог хаягдал
10. Зарим нэг иргэд оршин суугчид нэг хэсэг нь хог хаядаг нөгөө хэсэг нь түүж цэвэрлэх ёстой гэсэн буруу бодолтой
11. Хог ачиж цуглуулдаг тээвэрлэдэг машин механизмууд хуучирсан хангалтгүй
12. Бага дунд сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд хог хаягдлын менежментийн талаар тусгай хөтөлбөрт хичээл оруулаж заах хэрэгтэй байна
13. Хууль эрх зүйтэй нийцсэн хог хаягдлын менежменттэй болмоор байна.
14. Улаанбаатархотын иргэдийн амьжиргааны төвшинг дээшлүүлэх хэрэгтэй байна

С Групп

1. Хог ачиж цуглуулах асуудлуудыг шийдэх үүнд (айл өрхийн, үйлдвэрийн, аюултай хог хаягдал) мөн гудамж, зам, хогийн сав г.м
2. Хог хаягдлын тээвэрлэлтийн асуудлыг шийдэх
3. Хогийн нэгдсэн цэг буюу дундын цэг байгуулах
4. Тохиромжтой дэд бүтцийг бий болгох
5. Хог хаягдлыг дахин боловсруулах

Д Групп

1. Гэр хорооллын далан, үерийн усны суваг шуудуунууд хог хаягдлаар дүүрч байна
2. Хог хаягдлыг ангилан ялгадаггүй
3. Хог хаягдлыг тээвэрлэдэг машин хэт хуучирсан хангалтгүй
4. Иргэдийн ухамсар дорой
5. Хог хаягдал агаар, ус, хөрсийг бохирдуулж байна

6. Гэр хорооллын зохион байгуулалт төлөвлөлт муу
7. Хог хаягдлын талаарх мэдээлэл, сургалт сурталчилгаа хог хаягдалтай холбоотой хууль дүрэм хангалтгүй
8. Айл өрхүүдийн хөршийн хамтын ажиллагаа муу бие бидээ хяналт тавьдаггүй
9. Хаягийн бүртгэл замбараагүй зохион байгуулалтгүйгээс хогийн төлбөр бүрэн хийгддэггүй
10. Нилээд хэмжээний хог хаягдал гаргаж байгаа малтай айл өрхүүд гэр хороололд нилээд байна

Хавсралт 5 Бага хуралд оролцогсдын үзэл бодол

Доорх санал солилцсон асуудлуудыг тус бага хурлын хоёр дахь өдрийн хөтөлбөрийн 4-р зүйлд оруулсан.

1. М. Золжаргал / Байгаль Орчны Яамны Тогтвортой Хөгжил Хүрээлэн буй орчны мэргэжилтэн

Миний хувьд өөрийн санал зөвлөгөө өгөхөөс өмнө уг асуудлыг хариуцсан салбарын мэргэжилтнүүдээс хэдэн асуулт асуумаар байна:

1. Уулын орой дээр буусан нилээд хэдэн айлуудад төрийн үйлчилгээ хүрч чадахгүй байгаа жишээ нь цас ихтэй очих боломжгүй, зам хальтаргаатай, зам хаалттай г.м шалтгаанаас тэгвэл энэ асуудлыг яах вэ энэ асуудал дээр саналаа хэлнэ үү?
2. Үйлдвэрийн хог хаягдал авахад ямар бэрхшээл байна саналаа хэлнэ үү?

Баянзүрх Дүүргийн Тохижолт Үйлчилгээний Компаны захирал Ц.Цогтсайхан уг асуултанд хот хөгжүүлэх бодлогод гэр хорооллын зохион байгууллатыг тусгаж оруулах хэрэгтэй байна, харин гэр хорооллын уулан дээр буусан айлуудад хогны машин хүрч чадахгүй байгаа гэдэг асуудал дээр Эрүүл мэндийн Яам бохирын тал дээр шийдвэр гаргаж өгөх хэрэгтэй. Гэр хорооллын ихэнх айлууд хашаандаа жорлон хийж бохироо дүүрэнгүүт гаргаж хаядаг тэр ч бүү хэл гэр хорооллын айлууд талхны мөнгөгүй тиймээс хог ачилтын хураамжыг нэмэгдүүлнэ гэдэг бодитой бус бодлого гэж бодож байна. Харин төрөөс бодлого явуулж ерөнхий татвар аваад түүнээс нь хог хаягдлын төлбөрийг авдаг болвол зүйтэй болов уу. Энэ асуудал дээрх миний өөрийн үзэл бодол бол хог хаягдлын талаар хангалттай судалгаа хийгдээгүй учраас хог хаягдлын төлбөрийг нарийн тогтоож чадахгүй байна иймээс хог хаягдлын төлбөрийг тогтооход бидэнд хог хаягдлын талаарх бүрэн цогц мэдээлэл, судалгааны материал хэрэгтэй байна.

2. Хан Уул Дүүргийн Тохижолт Үйлчилгээний компаний захирал П. Ганбаатар

Үйлдвэрийн хог хаягдлын талаар хэдэн зүйл хэлмээр байна. Компаниуд, үйлдвэрүүд зориулалтын хог ачиж цуглуулах машин байхгүйгээс ил задгай машинаар хогоо өөрсдөө зөөдөг. Энэ нь тээвэрлэж байх явцад гудамжаар цувруулж асгаад байгаль орчныг бохирдуулж халдварт өвчин үүсгэх нөхцөл бүрдүүлдэг. Одоогоор зөвхөн хэдхэн компани манай компанитай гэрээгээр ажиллаж хогоо ачуулдаг. Мөн барилгын хог хайрга, чулуу, шороо г.м их гардаг. Эдгээр барилгын хог хаягдлыг ногоон байгууламж хийх буюу дов толгодыг зүлэгжүүлэх байдлаар ашиглаж болно. *Шимгүй хөрсийг тусгай газар дарж булах хэрэгтэй.* Барилгын компаниуд нүх ухаж түүнээс гарсан шороогоо өөр тийш нь зөөдөг барилга барьж дууссанахаа дараа газраа тэгшилхээр нөгөө шороогоо авчирдаг. Уг ажлыг хог хаягдлыг тээвэрлэдэг компаниуд өөрсдөө ийм үйлчилгээ хийж тухайн байгууллагуудаас тээвэрлэлтийн хөлс авч болно. Хог хаягдлыг ачиж цуглуулдаг машинууд нилээд хуучирсан, бензин их иддэг, ил задгай онгорхой бүхээгтэй. Иргэд татвараа хогийн мөнгө төлдөг байх ёстой.

Б. Дэлгэрбаяр, Улаанбаатар хотын Захирагчын Ажлын Албаны Хот Тохижолтын хэлтсийн мэргэжилтэн

Барилгын Компаниуд өөрсдөө хогоо зөөдөг үү?

Тийм, ихэнх нь өөрсдийн машинаар хогоо зөөдөг. Зөвхөн хэдхэн компани манайтай гэрээтэй хогоо зөөлгөдөг.

Б. Баясгалан / Үйлдвэр Худалдааны Яамны үйлдвэрийн бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн

3. Олон нийтийн санал асуулга явуулж жижиг хэмжээний туршилтын 3 төсөл хэрэгжүүлэх хэрэгтэй байна.
 1. Цэвэр гудамжны загвар төсөл
 2. Үйлдвэрийн хог хаягдлын менежментийн загвар төсөл
 3. Эмнэлгийн хог хаягдлын загвар төсөл

Эдгээр загвар төслүүдийн үр дүнг олон нийтэд телевиз, сонин, радио г.м хэрэгслээр сайн сурталчилах. Уг загвар төслүүдээр хогийг ангилан ялгасны дараагаар хэдэн хувь нь дахин ашиглагдаж байгаа, дахин боловсруулах нь хир хэмжээтэй байгаа, хогийн хэмжээ хир их байгаа зэргийг загвар төслөөр харуулах хэрэгтэй. Хог түүгчдийг гудамжны цэвэрлэгчээр ажилуулж, цалин хөлс өгөх, байцаагч болгох, тайлан бичүүлэх үүнийг олон нийтэд сурталчилах г.м ажилуулж болж байна. Нэмж хэлэхэд, хог ачилтын төлбөр 30-40 %-тай энэ байдал удаан үргэлжилж байна. Төлбөрийн чадваргүй айл өрхийн судалгаа гаргаж тэдний төлбөрийг төсвөөс болон янз бүрийн тусламжаас гаргах.

4. Г. Бүдрагчаа/ Нийслэлийн Байгаль Орчны Газрын нийслэлийн байгаль орчны газрын дарга

Миний хувьд судалгааны хэмжээнд зохион байгуулагдаж байгаа бага хурлын ач холбогдолыг тун өндрөөр үнэлж байна мөн бага хуралд оролцож байгаа төлөөлөгчид та бүхэн идэвх санаачилгатай оролцож байгаад сэтгэл өндөр байна. Уг хатуу хог хаягдлын менежментийн талаар уламжлах хэдэн асуудал байна.

- Хог зайлшгүй гардаг. Хог хаягдлыг гадаа ил задгай хаядаг байдлыг болиулах сэтгэл зүйн орчин бий болгож өгөх үүнд хяналт тавих. Энэ нь хог хаягдлыг ачиж цуглуудаг машин теаникийг сайжруулах, санхүүгийн байдлыг дээшлүүлэх г.м хийхэд хөрөнгө мөнгө шаардах ажил ярихын оронд хамгийн эхэнд хийж болох зардал багатай ажил юм.
- Хог хаягдлыг дахин боловсруулах тухай: Энэ тал дээр зарим ажил хэдийн хийгдэж эхлэхээд байна жишээлбэл гялгар ууцыг дахин боловсруулж, усны савыг хайлуулж шонгийн мод хийж байна. Хүмүүс дахин боловсруулж болдог бүх зүйлсийг ашигалах хэрэгтэй.
- Хог тээвэрлэлтийн асуудлууд нэн ялангуяа дахин боловсруулагддаггүй хог хаягдлыг зөөх асуудал байна. Тээвэрлэлтийн шинэ технологийг нэвтрүүлэх, байгууллагуудын санхүүгийн байдлыг сайжруулах, хамгийн гол нь хог эхлээд өөрсдөө жалганд хаяж дараа нь хөрөнгө мөнгө гарган хогоо цуглуулахгүй байх тийм ёс суртахуун ухамсарт нь суулгах хэрэгтэй байна.
- Химийн хорт бодис хаях нэгдсэн цэгийг Сонгинохайрхан дүүргийн (Тахир Соёотод) байгуулахаар төлөвлөж байсан ба зураг төсөв нь зохиогдсон

хэдий ч санхүүгийн асуудлаас болж өнөөг хүртэл энэ асуудал хэргжээгүй байгаа.

- Улаанбаатар хотод “зуслан нэртэй” жилийн дөрвөн улиралд байдаг хүрээ нэмэгдлээ. Энд удахгүй нилээд асуудал гарч ирнэ. Зуслангийн үйл ажиллагааг нэгтгэн зангиддаг нэг байгууллаг байх хэрэгтэй байна. Шингэн төрлийн хог хаягдлын талаао бас ярих хэрэгтэй байх. Айл болгоны бохир энэ төсөлд тусгагдаж орсон эсэхийг мэдэхгүй байна. Удахгүй зуслангийн бохирын талаар нилээд асуудал үүсэх байх. Иймээс үүнийг төсөлд тусган оруулах хэрэгтэй байна.

5. Г.Болд / Нийслэлийн хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ зураг төслийн хүрээлэнгийн захирал

Хогийн нэгдсэн цэгийн байршлыг манай байгууллага шийдэх ёстой. Энэ жил бид 2020 он хүртэл хэргэдэгдэх хогийн цэгийн ерөнхий тодотголыг хийж дуусгана. Хогийн нэгдсэн цэгийн байршлын асуудлыг бид анхааралдаа авна. Хог бол миний хувьд үйлдвэрийн түүхий эд. Айл өрх оршин суугчдад хог хаягдлын менежментийн талаар мэдлэг олгож өгөх. үйлдвэрлэл хөгжихийн хирээр хогийн хэмжээ ихэсч байна. Иймээс төлөвлөлтийн эхний үед нь үүнийг анхааралдаа авах хэрэгтэй. Бид уламжлалыг бодолцоно. өвөг дээдсийн үеэс манайхан нүүхдээ бууриа цэвэрлээд нүүдэг байсан. үүнийг сануулж хүмүүсийн ёс суртахууныг дээшлүүлэх хэрэгтэй байна.

6. С.Бумаа /Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Газрын Төв Лабораторын эрхлэгч

Хяналтын байцаагчийн хувьд хог хаягдал нь үргэлж миний гол анхааралд байдаг. Энэ төсөлд хамтарч ажиллах сонирхолтой байна. Хог тээвэрлэж байгаа байгуулагуудад хяналтыг шилжүүлэх, мөн хариуцлагыг шилжүүлэх хэрэгтэй гэж боддог. Цацраг идэвхит химийн хог хаягдал ил задгай хаягдаж болохгүй ба үүнийг булж дарах ёстой. Үүнийг мастер төлөвлөгөөнд тусгайлан оруулах хэрэгтэй. Хог хаягдын бүтэц чанарт хийх судалгааны ажлыг тусгай групп гаргаж тусгайлан төлөвлөсөн төлөвлөгөөний дагуу хийх.Гэр хорооллын хог хаягдлуудад нянгийн хэмжээ хир их байгааг шинжлэх. Хөрсний найрлагад хар тугалга их хэмжээгээр илэрдэг. Хүнд металлууд илэрч байгаа газруудыг шинжлэж зориулалтын техник хэрэглэх. Хэрэв хөрөнгө мөнгөний асуудал төсвийг яамдуудад зөвшөөрвөл бид зрим нэг шинжилгээг хийж болно.

7. Н. Оюунцэцэг /Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Газрын Байгаль орчин дэд бүтцийн хяналтын хэлтсийн улсын байцаагч

Би энэ асуудал дээр нэг санал оруулья. дүүрэг, хороо, багийн засаг дарга нарыг татан оролцуулж тэдэнд сургалт явуулах

П. Ганбаатар /Хан Уул дүүргийн тохижилт үйлчлгээний компаны захирал

Акт торгууль нь эзэндээ чиглэж очдог баймаар байна. Ахуйн хог хаягдлыг айл өрхүүд хаядаг, үйлдвэрийн хог хаягдлыг үйлдвэрүүд хаядаг гэтэл Улсын Мэргэжлийн Хяналтын Газар дүрэм зөрчлөө гэж тохижилт үйлчилгээний компанийг торгодог. Хороо бүр ядаж нэг байцаагчтай болохгүй бол хүн хүрэлцэхгүй байна.

8. Ч. Оюунбаатар /Хан Уул дүүргийн Засаг Даргын Тамгын Газрын Тохижилт үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга

Бага хурал их үр дүнтэй боллоо. Хэлэх зүйл их байна гэхдээ улсын хөрөнгө мөнгө хир билээ үүгээр хязгаарлъя. Уг төслийг санаачилсан хүмүүст би талархлаа илэрхийлмээр байна. Төрийн байгууллагууд болоод иргэдийг өргөнөөр татан оролцуулах хэрэгтэй байна. Жил бүр 1-2 том арга хэмжээ зохион байгуулж нийслэлийн бүх компани байгууллагуудыг татан оролцуулах хэрэгтэй. Хяналтын байгууллагын сүр хүчийг үзүүлж бүх байгуулага болон компаниудад хог хаягдлын менежментийн хүрээнд сургалт явуулах. Холбогдох мэдээлэл ,тайланг олон нийтэд сурталчилах. Хуулийг сурталчлах,нэвтрүүлэх ажлыг тусгайлан тохиромжтой төвшинд явуулах, реклам сурталчилгааг телевизороор үзүүлж самбарт тавих, төрөөс хогний тал дээр ажиллаж байгаа байгууллага хүмүүсийн урамшуулах. Хүмүүсийг урмаар ажилуулах учир нь энэ салбарт ажиллаж буй хүмүүс ихэнх нь боовсрол багатай, амьдарлын боломж муутай хүмүүс байдаг. Монголын цаг агаарт тохирсон менежментийн төлөвлөгөө боловсруулах.

С.Бумаа /Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Албаны Төв Лабораторын эрхлэгч

Гудамжны хог хаягдлын хяналтыг тухайн дүүргийн ТҮК буюу үүнийг хариуцдаг удирдлагуудад шилжүүлэн өгөх хэрэгтэй.

М. Золжаргал хариулахдаа :

Бүх шатны засаг дарга нар хяналт тавих үүрэгтэй. Тэд олон нийтийн байцаагч нарыг томилон ажмлуулах ёстой. Энэ асуудал дээр засаг дарга нарын эрх мэдэл хүрэхгүй үүнийг ТҮК юм уу өөр бусдад эрх мэдлийг нь шилжүүлэх нь дээр гэв.

9. Нөөц Компаны захирал Б. Наран

Янз бүрийн яамдууд , байгууллагуудын төлөөлөгчид болон мэргэжилтнүүд энэхүү бага хуралд оролцож байгаа нь их ач холбогдолтой зүйл боллоо. Хяналтын тогтолцоог сайжруулахгүй бол хүндрэлүүд гарсаар л байх болно. Хог хаягдлын менежментээ шийдвэрлэсэн орнуудын туршлагаудыг оруулж өгөх хэрэгтэй. Зардлын тооцоог хянаж үзэх хэрэгтэй. Хог ачиж цуглуулах төлбөрийг 1999 онд тогтоосон хэвээр байгаа нь хог тээвэрлэдэг компаниудыг алдлагдалд оруулж байна. Хог хаягдыг зөөж тээвэрлэдэг зориулалтын машин оруулж ирэх хэрэгтэй. Хог хаягдлын нэгдсэн цэгийн ажлын байрны орчинг сайжруулах хэрэгтэй гараж, дулаан байр, ус , цахилгаанаархангах г.м

10.Р. Дондов /Сонгино Хайрхан дүүргийн ТҮК-ийн захирал

Гаднаас машин механизм оруулж ирж байгаа хувийн компаниудад тусгай хөнгөлөлт үзүүлэх. Ж/нь Сод Монгол компани гэр хорооллын айлуудад тавих том хогийн сав оруулж ирж байгаа бөгөөд импортын татврын асуудлыг ярилцаж байгаа. Энэ асуудал дээр янз бүрийн байгууллагуудын үүрэг хариуцлагын ажлын зааг ялгаа байхгүй. Хуулиас гадна хот юу хийх ёстой юуг хариуцдаг дүүргүүд юу хийх ёстой юуг хариуцдагийг тодорхойлсон заавар зөвлөмж байх хэрэгтэй байна. Гэтэл одоо бүр зүйл ТҮК-үүдэд үлдлээ. Их хог гаргадаг бүтээгдэхүүнд гаалиас тусгай төлбөр тавьж хог хаягдлыг цэвэрлэдэг байгуулагуудад тавьж өгөх хэрэгтэй.

11. Содномпил /Байгаль Эрдэнэ сангийн төрийн бус байгууллагын захирал

Уг төсөл дээр цаг зав мөнгөө зарцуулсан JICA-ийн багт талархснаа илэрхийлмээр байна. Өнгөрсөн үеүүдэд ганцхан хуультай бүх юм эмх цэгцтэй байлаа харин одоо маш олон төрлийн хуулиуд гарсан ч хэрэгжиж байгаа нь ер алга. Иймээс энэ явуулаж буй арга хэмжээ нь туйлын тустай үйл явдал боллоо гэж боож байна. Нэн ялангуяа сургууль, хүүхдийн цэцэрлэгүүд ТВ, радиогоор сурталчилах хэрэгтэй. Саяхан Сэлбэ голын тухай сургуулийн хүүхдүүдийн дунд зургийн уралдаан зохион байгуулсан. Уг зургийн уралдаанд 2-р ангийн охин Сэдбэ голын хогноос айгаад арслан Сэлбэ голын гүүрнээс зугтаж байгаа арслан зурсан байсан. Хог хаягдлыг дахин боловсруулах болон Дундын цэгийг дүүргүүдийн дунд байгуулах хэрэгтэй байна. Дахин боловсруулж ашиглаж болохгүй хог хаягдлыг хогийн нэгдсэн цэгрүү хаявал хог түүгчид байхгүй болно. Төрийн бус байгуулагууд бол маш сайн ажиллах хүчин, тэдгээрийг ашиглах, дэмжих уг төлөвлөгөөнд татан оролцуулах хэрэгтэй байна.

12. Б. Наранмөнх / Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын Газар Тохижилт Үйлдвэрлэл үйлчилгээний хэлтсийн дарга

Хамгийн гол нь хогийг үнэтэй болгох болов сронгүй менежментийн систем байгуулах хэрэгтэй байна. Айл өрхүүдийн хог хаягдлын менежментийг сайжруулах хэрэгтэй. Төр засгаас хогийг ялган ангилдаг, дахин боловсруулдаг, буюу экспортолдог компаниудыг дэмжих зарим татварт хөнгөлөт үзүүлэх г.м. Менежментийн тал дээр ТҮК-ийг татан оролцуулах, сонирхолыг нь татах, жишээ нь/ санхүүгийн аргаар г.м Тусгай бодлого боловсруулбал компаниуд өөрсдөө менежментээ дээшлүүлээд явна. Төрөөс дундын цэгийн үйлдвэрийн газрыг шийдэж өгөх.

13. Нийслэлийн Захирагчийн Ажлын Албаны Хот Тохижилтын Хэлтсийн мэргэжилтэн Б.Дэлгэрбаяр санал зөвлөгөөнийг хааж хэлсэн үг

Миний бодлоор хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах төслийн хүрээнд хийгдэж байгаа судалгааны бага хурал амжилттай явагдлаа гэж бодож байна. Хог хаягдлын менежменттэй холбоотой мэргэжилтнүүдийг бэлтгэж гадаад болон дотоодод мэргэжил дээшлүүлж янз бүрийн сургалтанд хамруулах ажил зохион байгуулагдана гэдэгт итгэлтэй байна.

Бага хурлын хоёр дахь өдрийн хөтөлбөрийн 6 -р зүйл буюу үнэлгээний хуудсанд бичсэн санал хүсэлтүүд

1. Н. Оюунцэцэг/ Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Газрын байгаль орчны байцаагч

- Менежментийн хүмүүсийг татн оролцуулах

2. Бадамбазар Сүхбаатар дүүргийн засаг даргын тамгын газар

Сүхбаатар дүүргийн 13-р хороог загвар төслийн газар болгож оруулмаар байна. Мөн энэ тал дээр хамтранажиллаж дүгнэлтэнд хүрэх хэрэгтэй байна.

Нэмж хэлэхэд, уг төслийн туршид гэр хорооллын үнсийг дахин ашиглах жижиг хэмжээний төслийг хэрэгжүүлэхэд хамтарн ажиллах санал гаргаж байна.

3. П. Энхтуяа / Засаг Даргын Тамгын Газрын Хот Тохижилтын хэлтсийн мэргэжилтэн

А. Хог хаягдлын менежментэд хоблоотой ажилладаг ажиллагсдыг гадаад дотоодод явуулж хатуу хог хаягдлын менежментийн богино болон урт хугацааны сургалтанд хамруулж сургах

Б. Хог хаягдлыг зөөн тээвэрлэдэг холбоотой байгууллагуудад хог хаягдлыг зөөдөг болон цас цэвэрлэдэг машинаар хангах

В. Хог хаягдлыг дахин боловсруулж 2-догч түүхий эд бэлтгэдэг компаниудыг дэмжиж бага хэмжээний төсөл хэрэгжүүлэх

4. Б. Дэлгэр баяр / Нийслэлийн Захирагчийн Ажлын Албаны Хот Тохижилтын Хэлтсийн мэргэжилтэн

Уг бага хурлыг зохион байгуулж буй JICA-ийн хамт олон, ЗДТГ, ЗАА-д талархаж байгаагаа илэрхийлье. Тус бага амжилттай үр дүнтэй болж өнгөрлөө. Бага хурлын явцад оролцогсдын дэвшүүлсэн санал хүсэлтүүд уг төслийг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж би бодож байна.

5. Ч. Оюунбаатар /Хан Уул дүүргийн Засаг Даргын Тамгын Газрын Тохижилт үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга

УБ хотын бүх байгууллагуудыг зөвхөн ТҮК-ээр хогоо ачуулдаг болгох

Азийн Хөгжлийн Банкнаас ТҮК-үүдэд зээл тусламж олгох эсвэл олон улсын байгууллагаас хог хаягдлын цэвэрлэгээнд зээл олгодог болгох г.м

1. Д. Сүхбат / Сүхбаатар Дүүргийн ТҮК-ийн менежер

Бага хурал үр дүн сайтай явагдлаа гэж би бодож байна. Хурал дээр ярилцсан асуудлууд бодит биелэлээ олно гэдэгт итгэлтэй байна. Баярлалаа

2. Б. Батнасан / Налайх дүүргийн ТҮК-ийн менежер

ТҮК-ийн ажиллагсдыг сургалтанд хамруулж мэдлэг чадварыг нь дээшлүүлэх

3. Д. Баатархүү / Багахангай дүүргийн Тохижилт үйлдвэрлэл үйлчилгээний хэлтсийн дарга

6. 7-р хороо, 1-р хороо, 2-р хороо, 3-р хороо	Түрлэг 2, 200 м	Түрлэг 2, 200 м	Түрлэг 2, 200 м	Түрлэг 2, 200 м



3. Боломжит газруудын танилцуулга: хувилбаруудын судалгаа, дүн шилжлэгэ

Хувилбар	Зохион байгуулалт
1-р хувилбар	6 дүрэг → НЭХЦ
Нарангийн энгэр	Налайх дүүрэг → ННХЦ
2-р хувилбар	6 дүрэг → ЖМХЦ
ХМК	Налайх дүүрэг → ННХЦ
3-р хувилбар	6 дүрэг → ШС → МДХЦ
Морингийн даваа	Налайх дүүрэг → ННХЦ
4-р хувилбар	6 дүрэг → ЦДХЦ
Цагаан даваа	Налайх дүүрэг → ННХЦ
5-р хувилбар	6 дүрэг → ШС → БХХЦ
Баянгийн хонхор	Налайх дүүрэг → БХХЦ
6-р хувилбар	6 дүрэг → ШС → ТЭ → ШС → БННХЦ
Балагуурын нууц	Налайх дүүрэг → ННХЦ



Хог хаягдлын цэгүүдийн нөхцлүүд (1)

Зүйл	НЭХЦ-ийг ашиглах төлөвлөгөө	МЭӨЦ	МЭӨЦ
1. Сүрьеэний ашигласан бичил	Урсгал 20 өрчим түрүүлж	Сүрьеэний ашигласан бичил	Урсгал 20 өрчим түрүүлж
2. Үрэгдүүлэгч ашигласан бичил	Орчим сууц оролголт багасуулж	Төрдөр ашигласан бичил	Төрдөр ашигласан бичил
3. Хүний хэвсэг ашигласан бичил	50 га ажлын талбай	Хүний хэвсэг ашигласан бичил	50 га ажлын талбай
4. Хүний хэвсэг ашигласан бичил	Баруун талд 7 м	Хүний хэвсэг ашигласан бичил	Баруун талд 20.3 м
5. Хүний хэвсэг ашигласан бичил	13 м	Хүний хэвсэг ашигласан бичил	23 м
6. Хуульчлалтын зориулалтын сай	1.5 м	Хуульчлалтын зориулалтын сай	2.0 м
7. Хөдөө ажлаар ашигласан бичил	1.5 м	Хөдөө ажлаар ашигласан бичил	1.7 м



Газруудын тодорхойлолтууд

Таблица	Нэгж	НЭХЦ	МЭӨЦ	МЭӨЦ	МЭӨЦ	МЭӨЦ		
1. Дээрх бүлэг	м²	4	20	7	25	31	18	14
2. Дээрх бүлэг	м²	3,807,000	417,000	3,800,000	3,875,000	3,200,000	3,800,000	3,800,000
3. Дээрх бүлэг	м²	2,264,000	301,000	2,170,000	2,545,000	2,271,000	2,515,000	2,515,000

Эрүүл ахуйн шаардлага хангасан хог хаягдлын цэгийн сарын үйл ажиллагааны зардал

Ажилтай байр	Сарын зардал (Төгрөг/сар)	Тайлбар
1. Өдөр тутам ажиллагааны зардал	180,000	Төлөвлөгөө болгож
2. Эхний үеийн зардал	37,900,000	Бүтэц, эхлэл, хөдөлгөөн, үйлчилгээний зардал, үйлчилгээний зардал, үйлчилгээний зардал, үйлчилгээний зардал, үйлчилгээний зардал
3. Хог хаягдлын зардал	1,118,000	Ажиллагааны зардал, үйлчилгээний зардал, үйлчилгээний зардал, үйлчилгээний зардал, үйлчилгээний зардал
4. Хувиаргүй зардал	54,000	Хувиаргүй зардал, үйлчилгээний зардал, үйлчилгээний зардал, үйлчилгээний зардал, үйлчилгээний зардал
Дүн	38,258,000	
Нэг төмрөг ажиллагааны зардал	2,882 төгрөг/сар	2010 оны хог хаягдлын зардал
	13,353 төгрөг/сар	2010 оны хог хаягдлын зардал

Хог хаягдлын цэгүүдийн нөхцлүүд (2)



Зүйл	МЭӨЦ	МЭӨЦ	МЭӨЦ	МЭӨЦ
1. Сүрьеэний ашигласан бичил	Төрдөр ашигласан бичил	Мөнгөний ашигласан бичил	Хүний хэвсэг ашигласан бичил	Хүний хэвсэг ашигласан бичил
2. Үрэгдүүлэгч ашигласан бичил	Төрдөр ашигласан бичил	Төрдөр ашигласан бичил	Төрдөр ашигласан бичил	Төрдөр ашигласан бичил
3. Хүний хэвсэг ашигласан бичил	50 га ажлын талбай	Хүний хэвсэг ашигласан бичил	Хүний хэвсэг ашигласан бичил	Хүний хэвсэг ашигласан бичил
4. Хүний хэвсэг ашигласан бичил	Хүний хэвсэг ашигласан бичил	Хүний хэвсэг ашигласан бичил	Хүний хэвсэг ашигласан бичил	Хүний хэвсэг ашигласан бичил
5. Хүний хэвсэг ашигласан бичил	10 м	Хүний хэвсэг ашигласан бичил	38 м	130 м
6. Хуульчлалтын зориулалтын сай	4.0 м	Хуульчлалтын зориулалтын сай	0.6 м	3.0 м
7. Хөдөө ажлаар ашигласан бичил	1.2 м	Хөдөө ажлаар ашигласан бичил	0.6 м	0.3 м




6 боломжит газрууд дээр хог хаягдлын цэг байгуулах анхан шатны зардал

Боломжит газрууд	МЭӨЦ	МЭӨЦ	МЭӨЦ	МЭӨЦ	МЭӨЦ	МЭӨЦ
1. Газрууд	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000
2. Газрууд	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000
3. Газрууд	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000
4. Газрууд	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000
5. Газрууд	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000
6. Газрууд	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000
7. Газрууд	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000
8. Газрууд	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000
9. Газрууд	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000
10. Газрууд	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000	13,000,000

Нэг төмрөг ажиллагааны зардалын харьцуулалт




Шинэ хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах барилгын зардалын харьцуулалт



Санхүүгийн дүн шинжилгээний хураангуй дүгнэлт (1)


Зүйл	Нэгж	МЭӨЦ	МЭӨЦ	МЭӨЦ
1. Газрууд	Төгрөг/сар	15,364	13,227	19,323
2. Газрууд	Төгрөг/сар	3,125	3,396	3,307
3. Газрууд	Төгрөг/сар	18,489	17,123	22,830
4. Газрууд	Төгрөг/сар	1,949	1,712	2,280
5. Газрууд	Төгрөг/сар	20,338	18,855	25,113
6. Газрууд	Төгрөг/сар	394	337	449
7. Газрууд	Төгрөг/сар	1,056	1,515	2,021
8. Газрууд	Төгрөг/сар	1,056	1,515	2,021
9. Газрууд	Төгрөг/сар	7,025	7,807	6,224
10. Газрууд	Төгрөг/сар	4,814	4,585	5,981



Санхүүгийн дүн шинжилгээний хураангуй дүгнэлт (2)

Зүйл	Нэгж	МЭӨЦ	МЭӨЦ	МЭӨЦ
1. Газрууд	Төгрөг/сар	15,123	21,058	27,367
2. Газрууд	Төгрөг/сар	3,575	3,326	3,290
3. Газрууд	Төгрөг/сар	18,899	24,984	31,027
4. Газрууд	Төгрөг/сар	1,870	2,439	3,103
5. Газрууд	Төгрөг/сар	20,589	28,827	34,130
6. Газрууд	Төгрөг/сар	4,585	0,586	0,586
7. Газрууд	Төгрөг/сар	398	460	610
8. Газрууд	Төгрөг/сар	1,056	2,198	2,748
9. Газрууд	Төгрөг/сар	8,719	10,598	13,599
10. Газрууд	Төгрөг/сар	4,997	0,599	7,897

Нэг үндэс нэгдүгээр хамгийн төлбөрийн дундаж хэмжээ, саяд



Анхэн шалтны хөрөнгө оруулалт



Анхаарал тавьсанд баярлалаа

Хавсралт 6: Оролцогчдын санал асуулт болон тэдэнд өгсөн хариулт

А6.1. Ирээдүйн хогийн цэг болгон сонгох боломжит газруудын талаар

1. Байгаль Орчны Яамны Стратеги төлөвлөлт, бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн Ш.Дагва:

Миний ойлгож байгаагаар хог хаягдлын хэмжээ бүтцийн асуудал дээр хогны илчлэг бүтэц, ясны асуудал гарсангүй энэ талаар лавлаж асуух гэсэн юм.

Судалгааны Багийн Ахлагч Сүсүмү Шимура: Энэ асуудлыг гал тогооны хогны асуудалд оруулсан байгаа.

2. Сонгинохайрхан дүүргийн 4-р хорооны засаг дарга Т. Ганболд:

Юуны өмнө богино хугацаанд маш их зүйлийг амжуулж хийсэн судалгааны багийнханд талархлаа илэрхийлье. Улаанчулуутын хогийн цэг, Нарангийн Энгэрийн хогийн цэгүүд нь Сонгинохайрхан дүүргийн 4-р хорооны нутаг дэвсгэрт байрладаг. Улаанчулуутын хогийн цэгийг сайжруулах туршилтын төслийг хэрэгжүүлэх үед хогийн цэг дээр нилээд хэдэн хог түүгчид байх тул эдгээр хүмүүст хязгаарлалт хийхгүй бол замбараагүй байдал үүснэ. Иймээс, хогийн цэгрүү ороход нь хязгаарлалт хийх хэрэгтэй. Эцэст нь дүгнэж хэлэхэд, уг туршилтын төслийн явцад хог түүгчдийг хогийн цэгрүү ороход хязгаарлалт хийх нь тун чухал асуудал тул энэ тал дээр судалгааны багийнхан манай хорооны захиргаатай хамтарч ажиллахыг хүсч байна.

Судалгааны Багийн Ахлагч Сүсүмү Шимура: Улаанчулуутыг сайжруулах туршилтын төслийн явцад бид хогийн цэгрүү хүрэх зам барих гэж байгаа бөгөөд нэмж хэлэхэд хогны машины жолооч нарт хогийн цэг дээр хогоо хаана буулгах талаар тусгайлан зааварчилгаа өгнө. Мөн хогны машины жолооч нарт зориулан бидний зааварчилсан газар хогоо буулгах хуваарь гаргах бөгөөд жишээлбэл өглөө 8-9 цагийн хооронд нэг газар дараа нь 10-11 цагийн хооронд өөр газар буулгах г.м зохицуулалт хийх юм. Туршилтын төсөл хэрэгжүүлж эхлэхээс өмнө бид хог түүгчидтэй хамтарч ажиллан аюулгүй байдлыг хангахын тулд тэдэнтэй уулзаж ярилцлагын судалгаа хийнэ.

Захирагчийн Ажлын Албаны Хот Тохижилтын Хэлтсийн мэргэжилтэн Б.Дэлгэрбаяр: 2005 оны 4 сарын 18,19-ны өдрүүдэд бид хог түүгчидтэй ярилцлагын судалгаа зохион байгуулна. Тогтвортой хотуудын санаачилга, Канадын Сан, Нэгдсэн Үндэстний Хөгжлийн Хөтөлбөрийн санхүүжүүлсэн “УБ хотын хог түүгчдийн амьжиргааг сайжруулах” төсөл дээр хамтарч ажиллах саналыг манай Захирагчийн Ажлын албанд тавиад байгаа бөгөөд уг төслөөс хог түүгчдийг явал хог түүдэг арга барилаас өөрчлөх вэ? тэднийг вакцинжуулах, бүртгэлд оруулах арга хэмжээнүүдийг зохион байгуулахаар хамтран ажиллаж байна.

3. Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газрын Хотын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Ч. Батсайхан:

Ирээдүйн хогийн цэг дээр ямар зүйлсүүд хийгдэх вэ энэ тал дээр жаахан тодруулж өгнө үү?

Судалгааны Багийн Ахлагч Сүсүмү Шимура:

1. Юуны өмнө далангаа үерийн болон урсацын уснаас хамгаалахын тулд ус шүүрүүлэх байгууламж хийнэ. Мөн түүнчлэн хогоо салхинд хийсгэхгүйн тулд далан дээрээ торон хашаа барина.

2. Уулын хөндийн хамгийн нам доор газар уулын ёроолд далан барина ингэснээр хогоо доороос нь дээш нь хаях боломжтой болно гэсэн үг өөрөөр хэлбэл хуучин байдлаар дээрээс нь доош нь биш. Мөн бохир шингэн цуглуулах байгууламжийг бас барина.
3. Хогийн эцсийн цэгрүү хүрэх хатуу хучилттай зам барина.
4. Улаанчулуутын хогийн цэгийн орох хэсэгт хогийн жин хэмжих төхөөрөмж буюу автопүү суурилуулж хяналтын байр хийнэ.
5. Хогийн цэгийн ойролцоо 1 км орчим газраас өндөр хүчдлийн шугамнаас трансформатраар дамжуулан хяналтын байрлуу цахилгаан татна. Ерөнхийдөө ирээдүйн хогийн цэгийн хамгийн чухал шаардлага бол өдөр тутам хогоо дарж булах явдал юм. Бид Улаанчулуутыг сайжруулах төслийн хүрээнд тусгайлан зардал төсөвлөж өдөрт 1 бульдозер 8 цаг ажиллахад 300 литр дизель зарцуулахаар тооцоолсон.

Захирагчийн Ажлын Албаны Хот Тохижилтын Хэлтсийн мэргэжилтэн Б.Дэлгэрбаяр Хотын захиргаанаас 1 м³ хогийг дарж булахад зардлыг 100 төг байгааг 300 төгрөг болгож өсгөх төлөвлөгөөтэй байгаа гэв.

4. Хан Уул Дүүргийн Засаг Даргын Тамгын Газрын Үйлдвэрлэл Тохижилт Үйлчилгээний хэлтсийн дарга Ч. Оюунбаатар:

Хогийн цэгийн радиусын талаар асуух гэсэн юм, радиус нь хэдэн метр вэ? Түрүүчийн илтгэлд үзүүлсэнчлэн бусад орнуудынх шиг ойн зурвас байгуулах шаардлагатай гэж бодож байна. Миний бодлоор салхины чиг, жилийн дундаж салхины хурд, хүчийг тооцон ойн зурвас байгуулах шаардлагатай. Талбайн хэмжээг тооцсон уу? Эдгээр үзүүлэлтүүдийг судалгаандаа оруулаж тооцсон уу? Эцэст нь хэлэхэд, Ландфил бүхий хогийн цэгийн радиусыг мэдмээр байна.

Судалгааны Багийн Ахлагч Сүсүмү Шимур: Хогийн цэгийн ойролцоо ойн зурвас байгуулах асуудал Монголд бараг л хэрэгжихгүй болов уу учир нь экологи нь нилээд навчистай том моднуудад ерөнхийдөө тохиромжгүй.

Монгол Улсын Их Сургуулийн профессор Гончигсумлаа: Өнгөрсөн намраас эхлэн ЖАЙКА-ийн судалгааны багтай уг судалгааны ажил дээр хамтарч ажиллаа. Миний хувьд судалгааны ажлыг нягт нямбай хийж гүйцэтгэсэн гэж бодож байна. Гэвч УБ хот орчим нь ерөнхийдөө салхирхаг нутаг тул ирээдүйн хогийн цэгийг салхи багатай газар сонгож байгуулах нь зөв. Ийм шаардлага хангасан газар УБ хотод их ховор. 6 боломжит газрууд бүгд салхитай газар тул салхинаас хамгаалах арга бол хашаа барих явдал юм. Бусад орнуудад ойн зурвас байдаг гэхдээ манайд ч бас болох л асуудал харин манайд хийгдэж чадахгүй л болов уу. Манай орны хувьд 3,4,5,8,9,10-р сарууд гол салхитай байдаг улирал.

Захирагчийн Ажлын Албаны Хот Тохижилтын Хэлтсийн мэргэжилтэн Б.Дэлгэрбаяр хогийн цэгийн радиусын тал дээр би нэг товч тайлбар хийе. Ландфил бүхий хогийн цэгийн ус шүүрүүлэх байгууламжийн радиус нь 3 км, талбайн хэмжээ нь 30 га. Нарангийн Энгэрийн хогийн цэгийн радиус 3 км, ХМК-ийн радиус 2 км, Нарандаваагийн радиус 3 км, Багануурын радиус 3 км, Цагаандаваагийн радиус 3.2 км, Налайхийн радиус 3 км байна.

5. Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газрын Хотын Хөгжлийн Бодлого Төлөвлөлтийн Хэлтсийн Дарга А. Зулгэрэл: Богино хугацаанд их ажил хийж амжуулсан ЖАЙКА-ийн судалгааны багийнханд талархлаа илэрхийлээд 2 асуулт асууя. 1. Ирээдүйн хогийн цэгийн ойролцоо хичнээн малтай айл байна вэ?

2. 2005 оны 7 сард барилгын хог хаягдал гарна энэ хог хаягдлын хэмжээг хог хаягдлын бүтцийн судалгаанд оруулсан уу?

Судалгааны Багийн Ахлагч Сүсүмү Шимура: Барилгын хог хаягдал бол нилээд хүндрэлтэй асуудал. Одоохондоо Улаанбаатар хотод барилгын хог хаягдлыг хаа сайгүй хууль бусаар хаяж байна. Улаанбаатар хотын төлөвлөгөөнд хичнээн хэмжээний барилга байшин нурааж хэдий хэмжээний хог гарах ёстойг тооцсон төлөвлөгөө байх ёстой. хэрэв ийм төлөвлөгөө байвал, хог хаягдлын хэмжээ бүтцийн тооцоонд оруулж болох юмаа.

Монгол Улсын Их Сургуулийн профессор Гончигсумлаа: Хот сууринд мал эрхлэх асуудлыг хориглосон байгаа. Иймд, энэ асуудал дээр орон нутгийн удирдлагатай ярьж тохиролцох хэрэгтэй.

Захирагчийн Ажлын Албаны Хот Тохижилтын Хэлтсийн мэргэжилтэн Б.Дэлгэрбаяр Жил ирэх тутам мал тооллогийн дүнгээр малын тоо багасч байна. Нарангийн Энгэрийн хогийн цэгийн хажууд ойрхон 50-60 м-т хуучин ашиглаж байсан шорооны орд газар байна.

5. Үйлдвэр Худалдааны Яамны Үйлдвэрийн Бодлого Зохицуулалтын Газрын мэргэжилтэн Б.Балгансүрэн:

Хичнээн хогийн цэгийг хэдий хугацаанд ашиглах вэ? Үйлдвэрээс гарч буй хог цэвэр байдаг учраас үйлдвэрийн хогийг дахин боловсруулах асуудал зайлшгүй яригдана. Нөгөө талаас, барилгын хог хаягдлыг хогоо дарж булах материал болгон ашиглаж болох юм.

Судалгааны Багийн Ахлагч Сүсүмү Шимура: Барилгын хог хаягдлыг жишээлбэл, бетон хавтан, туйпуу зэрэг барилгын материалыг хогийн цэг дотроо зам тавихад ашиглаж болох юм.

Захирагчийн Ажлын Албаны Хот Тохижилтын Хэлтсийн дарга Ц. Болд: Бидний дэвшүүлж буй зургаан боломжит хогийн цэгээс гурвыг нь сонгох хэрэгтэй байна. Тус сонгосон гурван хогийн цэгийг улмаар Удирдах Зөвлөлийн хуралд эцсийн байдлаар шийдүүлэхээр танилцуулах юм.

Байгаль Орчны Яамны Стратеги төлөвлөлт, бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн Ш. Дагва: Бид үйлдвэрийн хог хаягдлыг хортой ба хоргүй гэж 2 ангилдаг. Өнөөдөр бид энд үйлдвэрээс гарч буй хоргүй хог хаягдлын талаар ярьж. Үйлдвэрийн аюултай хог хаягдлын жагсаалт гарсан байгаа. Иймээс үйлдвэрийн аюултай хог хаягдлын талаар дараа жичэд нь ярилцая.

6. Барилга Хот Байгууллалтын Яамны Барилга, Нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн Б. Оюунчимэг:

Юуны өмнө энэхүү бага хурлыг зохион байгуулаж буй ЖАЙКА-ийн судалгааны багийнхан болон Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаныханд талархлаа илэрхийлье. Миний ойлгож байгаагаар, Нарангийн Энгэрийн хогийн цэгийн автомашины жин хэмжих төхөөрөмжийн зардал (автопүүний зардал)-ыг нойл гэж төлөвлөсөн байна. Иймээс энэ зардал яагаад нойл гэж төлөвлөсний учрыг тайлбарлаж өгнө үү?

Судалгааны Багийн Ахлагч Сүсүмү Шимура: Та тун зөв асуулт асуулаа. Улаанчулуутын хогийн цэгийг сайжруулах туршилтын төслөөр Улаанчулуутын хогийн цэгийн орох хэсэгт автомашины жин хэмжих төхөөрөмж автопүү суурилуулах зардлыг бид аль хэдийн төсөвлөсөн. Харин Нарангийн Энгэрийн хогийн цэгийн хувьд Улаанчулуутын хогийн цэгийн цаахан талд буюу өөрөөр хэлбэл нэг уулын наана цаана 2 байрлалтай байгаа тул Нарангийн Энгэрийг хогийн эцсийн цэг

байгуулахад тохиромжтой газар хэмээн сонгосон тохиолдолд Улаанчулуутын хогийн цэгт суурилуулсан автопүүнээс Нарангийн Энгэр хүртэл зам тавина. Ингэснээр, бид Улаанчулуутын автопүүг Нарангийн Энгэрт хэрэглэх боломжтой болох тул Нарангийн Энгэрийн хогийн цэгийн анхан шатны зардал буюу автопүү суурилуулах зардлыг (0) гэж төсөвлөсөн юм.

7. Сонгинохайрхан дүүргийн Засаг Даргын Тамгын Газрын Үйлдвэрлэл, Тохижилт Үйлчилгээний Хэлтсийн Дарга Ц. Нүүдэл:

Өнөөдрийн байдлаар Сонгинохайрхан дүүрэгт байрладаг Улаанчулуутын хогийн цэг дээр 6 дүүрэг хог хаяж байна. Улаанчулуутын хогийн цэгт хамгийн ойрхон оршиж буй хороо бол манай дүүргийн 6-р хороо иймд хорооны иргэд орчны бохирдол, тоос, энд тэндгүй салхинд хийсч хаягдсан хогийн талаар байнга гомдоллодог. Нэн ялангуяа бүхээгүй тэвштэй хогны машинууд хогоо бүтээдгүйн улмаас хогийн цэгрүү аваачиж асгах замдаа хогоо замаар нэг хийсгэдэг мөн хогийн цэгрүү аваачиж хогоо асгах машины тоо хэдий чинээ их байна төдий чинээ тоос 6-р хорооны нутаг дэвсгэрт үүсдэг. Иймд энэ асуудал танай судалгаанд харъяалагдаж байна уу үгүй юү гэдгийг мэдэх гэсэн юм.

Судалгааны Багийн Ахлагч Сүсүмү Шимура: Бид Улаанчулуутын хогийн цэг дээр Ажлын Зураг Авалтын Судалгаа хийсэн тэвштэй хогны машинуудад хогоо дээгүүр нь бүтээх бүтээлэг их шаардлагатай байгааг олж мэдсэн. 6-р хорооны тоосжилтын хувьд одоо байгаа засмал замаас Улаанчулуутын хогийн цэг хүртэл хатуу хучилттай зам тавина. Мөн бид Улаанчулуутын хогийн цэгт автопүү суурилуулаад Нарангийн Энгэрийн хогийн цэгт ашиглана замыг нь хойшоо Нарангийн Энгэрлүү орохоор тавина.

8. Эрүүл Мэндийн Яамны Бодлого Зохицуулалтын Газрын орчны нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ш. Энхцэцэг:

Би хортой хийн талаар асуумаар байна. Хортой хийн судалгаа шинжилгээ хийсэн үү? Та түрүүн 1 бульдозер өдөрт 8 цаг ажиллахад 300 литр дизель ашиглана гэж хэлсэн энэ маань юу гэсэн үг вэ гэвэл туршилтын төсөл хэрэгжих явцад тухайн орчинд агаарын бохирдол үүснэ гэсэн үг. Ялангуяа уг хогийн цэгийн ойр орчимд амьдарч байгаа иргэдэд нөлөөлөх агаарын бохирдолыг анхаарч үзэх хэрэгтэй. Мөн надад бас нэг асуулт байна. Эмнэлгийн хог хаягдлыг хогийн цэг дээр хаяхаар тооцоолсон уу? Эмнэлгийн хог хаягдлыг хаана хаях вэ?

Судалгааны Багийн Ахлагч Сүсүмү Шимура:

Хогноос хортой хий үүсдэг өөрөөр хэлбэл сульфид, метаны хий ялгардаг. Эдгээр хогноос ялгардаг хортой хийний асуудлыг шийдэхийн тулд бид хортой хийг зайлуулдаг (сорж авдаг) тоног төхөөрөмж суулгаж өгнө. Хогийн цэг дээр ердөө л 3 бульдозер ажиллах тул нэг их утаа гарахгүй гэдэгт итгэлтэй байна. Замын барилга ажлын талбайд бульдозер, эксковатор, индүү г.м хүнд механизмууд нэг доор ажилладгийг та бүхэн сайн мэдэж байгаа шүү дээ. Харин эмнэлгийн хог хаягдлын хувьд бол өдөрт гарч буй нийт ахуйн хог хаягдлын ердөө л 0.2%-ийг эмнэлгийн хог хаягдал эзлэж байна. Үүнээс харахад өдөрт гарч буй эмнэлгийн хог хаягдлын хэмжээ тун бага байна гэж би бодож байна.

9. Баянзүрх дүүргийн Тохижилт Үйлчилгээний Компаны захирал Ц.Цогтсайхан:

Хогийн цэгээс хамгийн хол оршдог дүүргийг би Баянзүрх дүүрэг гэж бодож байна. Самосвалаар тээвэрлэх 1 тон хог хаягдлын тээврийн зардлын хүснэгтэн дээр Баянзүрх дүүргээс хогийн цэг хүртэлх зай Сүхбаатар дүүргээс хогийн цэг хүртэлх

зайнаас ойрхон гэж тооцжээ. Иймд, Баянзүрх дүүргээс хогийн цэг хүртэлх тээврийн зайг зөв тооцож гаргасан юм уу?

Захирагчийн Ажлын Албаны Хот Тохижилтын Хэлтсийн дарга Ц. Болд:

Манай судалгааны багийнхан ажлын зураг авалтын судалгааг хийж судалгааны багийн мэргэжилтэн ноён Дои Акира Баянзүрх болон Чингэлтэй дүүргүүдийн хогны машиныг дагаж явсан. Баянзүрх дүүргээс хогийн цэг хүртэл 19 км байсан. Энэ бол дундажлаж авсан үзүүлэлт хэрэв бид Улиастайгаас нэг цэг сонгож аваад хогийн цэг хүртэл тооцвол зай нь хамаагүй их гарах нь мэдээж. Мөн үүн дээр нэмж хэлэхэд, Баянзүрх дүүргийн орон сууцны хороололын зам нь шулуун бөгөөд бартаа багатай мөн түүнчлэн Баянзүрх дүүргийн орон сууцны хогийг авдаг тусгай зориулалтын хогны машинууд нэг их дов толгод тойроод яваад байхгүй учраас км нь их гарахгүй байсан. Баянзүрх дүүргийн хогны машинууд шулуун замаар явдаг тул зай нь Сүхбаатар дүүргийнх шиг хол байгаагүй юм. Харин Сүхбаатар дүүргийн хувьд, хогны машинуудын хогийн цэгрүү явдаг зам нь дов толгод ихтэй, Баянзүрх дүүргийг бодвол тойруу байсан учраас Сүхбаатар дүүргийн хог тээврийн зай нь Баянзүрх дүүргийнхээс их гарсан байна.

10. Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын Газрын Нийгэм, эрүүл мэндийн хяналтын хэлтсийн улсын байцаагч Оюун:

Би хэдэн асуулт асуух гэсэн юм.

1. Бохир шингэнийг хадгалах байгууламжийн хүчин чадал хэдий хэмжээтэй вэ?

Дүүрэнгүүт нь ямар арга хэмжээ авах гэж байна?

2. Нарангийн Энгэрийн ойр байдаг худгийн усны шинжилгээг хаана хийлгэсэн бэ?

3. Хогийг ачиж цуглуулах тээвэрлэх хүчин чадлыг яаж тооцсон бэ?

Захирагчийн Ажлын Албаны Хот Тохижилтын Хэлтсийн мэргэжилтэн Б.Дэлгэрбаяр

Хогийг ачиж цуглуулах тээвэрлэх хүчин чадлыг нь тооцоходоо бид хогийг нягтаар нь тооцож гаргасан өөрөөр хэлбэл, 1м³ хогонд нягтаасаа шалтгаалж 300-400 кг хог байна гэж тооцсон. Одоогоор, Зил-130 маркын хогны машин 3.2 тон хог ачиж байна.

Судалгааны Багийн Ахлагч Сүсүмү Шимура:

Бид бохир шингэнийг хадгалах байгууламжийн эзлэхүүнийг 1300 м² гэж тооцоолсон. Монголын хувьд, жилд унах (борооны) хур тундасны хэмжээ 300-400 мм байдаг ба цаг агаар нь хуурай учир маш хурдан ууршдаг байна. Иймд, миний тооцоолж байгаагаар хүчтэй хур тунадас аадар бороо орж, үер буухгүй л бол ирээдүйн хогийн цэгт бохир шингэн бараг гарахгүй л болов уу. Бид ирээдүйн хогийн цэгт хир зэрэг бохир шингэн гарах вэ гэдгийг тооцоолно. Бидний тооцоолсноор, хогийн цэг дээр байгаа ахуйн хог хаягдлын 60%-ийг үнс ба зөвхөн 10%-ийг гал тогооны хог хаягдал эзлэж байна. Бас нэг асуудал бол хогийн цэгийн ариун цэврийн бүсийн асуудал юм. Энэ тал дээр, хотын захиргаанаас хүсэлт гаргаж энэхүү ариун цэврийн бүсэд ямар ч барилга байгууламж бариулахгүй байх тал дээр албан ёсны хүсэлт гаргах хэрэгтэй байна. Гэр хорооллын бүс өргөсч байгаатай холбогдуулан хогийн цэгрүү тэлж оруулахгүй байх үүднээс хогийн цэгийг тойруулаад ариун цэврийн бүс байгуулах хэрэгтэй байна. Худгийн усны шинжилгээний хувьд Монгол Улсын Их Сургуулийн мэргэжилтэн нөхөд хийсэн байгаа. Бидний хамтран ажиллагч Монгол Улсын Их Сургуулийн профессор Гончигсумлаа худгийн усны шинжилгээний талаар дэлгэрэнгүй тайлбар өгөхөөс өмнө би та бүхэнд Улаанчулуутын хогийн цэг дээр галын улмаас гарч буй утааны талаар хэдэн юм хэлье. Хогийн цэг дээр гал гарах асуудлыг шийдэхэд тун амархан та бүхэн өдөр бүр хогоо дарж булсан тохиолдолд гал гарах асуудал ердөө ч гарахгүй.

Монгол Улсын Их Сургуулийн профессор Гончигсумлаа:

Улаанчулуутын хогийн цэгийн өмнөд хэсэгт тэр хэсгийн айл өрхийн ахуйн хэрэгцээг хангадаг хэдэн гар худгууд байна. Тэдгээр худгуудын зарим нь бүртгэлтэй зраим нь бүртгэлгүй байсан. Эдгээр худгуунуудаас бид 4 худгийг сонгож авсан. Бараг л хотын төвд гэж хэлж болохоор хүн ам нягт төвлөрсөн хэсэгт ийм худаг байгуулсан нь нэг талаас ариун цэврийн хувьд их зохимжгүй байсан ийм худгуудад шинжилгээ хийсэн. Миний хэлж байгаа санаа бол ариун цэврийн шаардлага хангаагүй ийм худгуудад усны шинжилгээ хийсэн юм. Ингээд бид энэ усны хатуулаг ундны усанд тохиомжтой эсэхийг шалгасан мөн энэ усандаа хими, микробиологийн шинжилгээ хийсэн. Усны шинжилгээний дүнгээс харахад, микробиологийн бохирдолд орсон нь илэрхий байсан. Мөн цаашлаад, гүний усанд нөлөөлөх нь үү гэдэгт хяналт шинжилгээ хийж үзэхэд нөлөөлөж болохуйц гэсэн үр дүн гарсан.

Судалгааны Багийн Ахлагч Сүсүмү Шимура:

Би та бүхэнд хогийн цэг дээр гарч болох галаас яаж хамгаалах тухай зарим мэдээллийг Туркийн Адана хотын жишээн дээр тайлбарлаж өгье. Мөн түүнчлэн галын аюулаас хамгаалахын тулд ямар зүй зохистой арга хэмжээ авах ёстойг хэлж өгье. Туркийн Адана хотын хүн ам нь 1.2 сая буюу ойролцоогоор Улаанбаатар хотын хүн амаас 1.5 дахин их байсан. Адана хотын хогийн цэгийн нийт талбай нь 23 га байсан бөгөөд тус хогийн цэгт байсан хогнууд нийт талбайг хамран тэр чигээрээ шатаж байсан. Энэ үед бид зөвхөн хогийг дарж булаах арга хэмжээ авснаар гал гарах асуудал тэр чигээрээ зогссон.

Та бүхний анхаарал тавьсанд баярлалаа.

А.6.2 Хогийн эцсийн цэг байгуулахад боломжтой газруудын талаар группуудын өгсөн үнэлгээ

“А” Группын илтгэгч

1. Байгаль Орчны Яамны Стратеги төлөвлөлт, бодлого зохицуулалтын газрын мэргэжилтэн Ш. Дагва:

1. Нарангийн Энгэр

Манай групп та бүхний дэвшүүлж буй зургаан боломжит газруудын талаар хэлэлцэж 0-5 гэсэн үнэлгээний баллыг ашиглан доорх үнэлгээг өгч байна. Нарангийн Энгэрийн хогийн цэг нь Улаанчулуутын хогийн цэгтэй хамгийн ойр оршиж байгаагаараа нилээд хэдэн давуу, эерэг талуудтай байна. Нарангийн Энгэрийн хогийн цэгийн хувьд, ерөнхий нөхцөл байдал гэсэн шалгуур дээр Улаанчулуутыг сайжруулах туршилтын төслөөр хатуу хучилттай зам тавьж, цахилгаан эх үүсгүүр тун ойроос авч хэрэглэх боломжтой гэсэн дэд бүтцийн нөхцлүүдийг харгалзан бид (0) үнэлгээ өглөө. Мөн түүнчлэн, Нарангийн Энгэрийн хогийн цэг нь Улаанчулуутын хогийн цэгтэй тун ойрхон оршиж байгаа тул эдийн засгийн үр ашиг нь бусад боломжит газруудыг бодвол хавьгүй дээр байна. Улаанчулуутын хогийн цэгийг сайжруулах туршилтын төсөл хэрэгжүүлснээр гал гарсны улмаас гардаг утаа байхгүй болно, хөрсний бохирдол багасна, хогийн цэгийн ойролцоо бий болдог тоос ч багасна. Цаашилбал, хогийн цэгт барьж байгуулах даланг бороо үерийн усанд идэгдүүлэхгүйн тулд ус шүүрүүлэх байгууламж буюу шуудуу хийнэ. Эдгээр нөхцөл байдлыг харгалзан бид нийгмийн болон бохирдолын нөхцөл байдал дээр тус тус (0) гэсэн үнэлгээг өгч байна.

2. ХМК

ХМК-ийн хогийн цэгийн хувьд ерөнхий нөхцөл байдал гэсэн шалгуур дээр бид (0) үнэлгээ өгч байна. Харин ХМК-ийн нийгмийн болон бохирдолын нөхцөл байдлыг авч үзэхэд уг хогийн цэгийн эргэн тойрон иргэд оршин суугчид амьдардаг тул тэнд байгаль орчны бохирдол зайлшгүй үүснэ ингэснээр тухайн орчинд амьдардаг иргэдийн нийгмийн нөхцөл байдалд мэдээжээр нөлөөлнө. Иймд, уг хогийн цэгийн нийгмийн нөхцөл байдал гэсэн шалгуур дээр (3) оноо бохирдолын нөхцөл гэсэн шалгуурт (2) оноо өгч байна.

3. Морин даваа

Морин даваагийн хогийн цэг нь малын эм, тариа үйлдвэрлэдэг Биокомбинатын хориотой бүс ба малын бэлчээрийн хэсэгт байрладаг хогийн цэг юм. Иймд эдгээр нөхцлүүдийг харгалзан бид Морин даваагийн хогийн цэгт хогийн эцсийн цэгийг байгуулах нь нэг их тохиромжтой бус хэмээн үзэж уг хогийн цэгийн ерөнхий нөхцөл байдал гэсэн шалгуурт (1) оноо өгч байна. Морин даваагийн хогийн цэг нь Сонгины хориотой бүсэд орсон тул Биокомбинатын удирдлага удаа дараа уг хогийн цэгийг өөрсдийн хориотой бүснээс гаргуулах талаар албан мэдэгдэл өгсөн мөн түүнчлэн олон улсын онгоцны нисэх буудал энэ хогийн цэгтэй тун ойрхон байдаг тул хогийн цэг дээрх хог салхинд хийсэн орж ирнэ энэ маань бас л иргэдийн орчныг бохирдуулж иргэдийн нийгмийн нөхцөл байдалд нөлөөлнө. Энэ утгаараа Мориндаваагийн хогийн цэгийн нийгмийн буюу бохирдолын нөхцөл байдал гэсэн үзүүлэлт дээр тус тус (2) оноо өглөө.

4. Цагаандаваа

Цагаандаваагийн хогийн цэгийн хувьд дэд бүтэц байхгүй тул уг хогийн цэгийн ерөнхий нөхцөл байдал гэсэн үзүүлэлт дээр бид (2) оноо өгч байна. Энэ хэсэгт салхины чиглэл байнга өөрчлөгдөж байдаг. Цагаандаваагийн хогийн цэг нь нам дор газар буюу уулын аманд байрладаг тул тус хогийн цэг дээр хаясан хог бороо болон үерийн усанд угаагдаж энд тэндгүй хаягдах магадлал ихтэй. Иймд, бид эдгээр нөхцлүүдийг харгалзан нийгмийн нөхцөл байдал гэсэн үзүүлэлт дээр (2) оноо бохирдлын үзүүлэлт дээр 1 оноо өгч байна.

5. Баянгийн Хонхор

Баянгийн Хонхорын хогийн цэг нь нисэх хүчинтэй нилээд ойрхон оршдог. Мөн нилээд өргөн уудам бэлчээрийн газар. Иймээс, Баянгийн Хонхорын хогийн цэгийн ерөнхий нөхцөл байдал гэсэн шалгуур дээр (4) оноо өгч байна. Харин тус хогийн цэг нь дэд бүтцээс хол учир нийгмийн болон бохирдолын үзүүлэлт дээр тус бүр (3) оноо өгч байна.

6. Багануур

Уг хогийн цэгийн ерөнхий нөхцөл байдал гэсэн үзүүлэлт дээр (4) оноо өгч байна. Энд гүний ус гардаг 52 цооног байдаг тул хогийн цэг байгуулвал гүний усыг бохирдуулах нилээд өндөр магадлалтайгаас гадна ундны усыг ч бохирдуулах магадлалтай иймд бохирдолын үзүүлэлт дээр (4) оноо харин нийгмийн нөхцөл байдлын хувьд (1) оноо өгч байна.

“Б” Группын илтгэгч

2. Нийслэлийн Засаг Даргын Тамгын газрын Хотын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн Ч. Батсайхан:

Бид багаараа хэлэлцээд зургаан боломжит газруудын талаар доорх үнэлгээг өгч байна. Тус зургаан боломжит газруудын талаар дэлгэрэнгүй тайлбар өгөх цаг тун бага тул зөвхөн максимум, минимум оноог харьцуулж үнэлгээ өгье.

Ерөнхий нөхцөл байдал гэсэн үзүүлэлтийн хувьд ХМК нь бусад боломжит газруудыг бодвол хавьгүй дээр гэж үзэн хамгийн өндөр оноо буюу (0) өгч байна. ХМК нь байрлалын хувьд Улаанбаатар хотын төвд байрладаг тул бүх дүүргүүдийн хувьд тохиромжтой газар байрладаг. Харин Багануурын хувьд, хог ачиж тээвэрлэх зай хэт хол, үүнээс гадна эдийн засгийн ашиг багатай тул бид хамгийн бага буюу (5) оноо өглөө. Цагаандаваагаас зүүн өмнөд зүгт байрлаж буй хуучин Дарь Эхийн хогийн цэгт Улаанчулуутын хогийг цэгийг сайжруулах төсөл шиг ижил арга хэмжээ авбал ойр орчинд амьдарч буй иргэдийн орчин сайжирч иргэд сэтгэл хангалуун байх бөгөөд нийгмийн нөхцөл байдал нь хамаагүй дээшилнэ. Иймд, Цагаандаваагийн хогийн цэгт бид хамгийн өндөр оноо (0) өгч байна. Харин Багануурын хогийн цэгийн хувьд, гүний усыг бохирдуулах өндөр магадлалтай тул байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлнэ гэдэг утгаар хамгийн бага оноо буюу (5) оноо өгч байна. Бохирдолын үзүүлэлт дээр ХМК-д хамгийн бага буюу (5) оноо харин Нарангийн Энгэрийн хогийн цэгд хамгийн өндөр оноо (0) өгч байна. ХМК -ийн эргэн тойрон иргэд оршин суугчид амьдардаг суурьшлын бүс тул энэ хэсэгт Ландфил бүхий хогийн эцсийн цэг байгуулвал ойр орчны иргэдэд үзүүлэх орчны бохирдол нилээд их болж хогийн цэг дээр ажиллаж буй бульдозерийн дуу чимээнд ч иргэд сэтгэл хангалуун бус байж тавгүй орчин үүсгэнэ гэсэн үг иймээс ХМК-ийн хувьд хамгийн бага оноо (5) өглөө. Харин Нарангийн Энгэрийн хогийн цэгийн хувьд, Улаанчулуутын хогийн цэгтэй нилээд ойрхон оршдог нэмж хэлэхэд, Улаанчулуутын хогийн цэгийг сайжруулах туршилтын төслийг энэ хэсэгт хэрэгжүүлэх тул утаа гарах асуудал үгүй болж байгаль орчны бохирдлыг ч нилээд хэмжээгээр багасгах юм.

Бид хэлэлцэж тохиролцоод 6 боломжит газруудыг сайнаас нь эхлүүлээд байр эзлүүлэн доош нь жагсаав.

1. Нарангийн Энгэр
2. Цагаандаваа
3. Мориндаваа
4. ХМК
5. Баянгийн хонхор
6. Багануур

“С” Группын илтгэгч

3. Сонгинохайрхан дүүргийн Засаг Даргын Тамгын Газрын Үйлдвэрлэл тохижилт үйлчилгээний хэлтсийн дарга Ц.Нүүдэл:

Бид Удирдах Зөвлөлийн хуралд хэлэлцүүлэхээр боломжит газруудаас тохиромжтой гэж үзсэн 3 хогийн цэгийг сонголоо. Үнэнийг хэлэхэд, мэргэжлийн түвшинд нарийн мэдэхгүй тул бид дараах байдлаар 3 байр эзлүүлээ.

- 1-р байр Нарангийн Энгэр
- 2-р байр Цагаандаваа
- 3-р байр Багануур

“Д” Группын илтгэгч

4. Нөөц Компаний захирал Наран:

1970 оноос хойш Улаанчулуутын хогийн цэг дээр сүүлийн 30 жил Улаанбаатар хотын 6 дүүрэг хогоо хаяж байгаа билээ. Улаанчулуутын хогийн цэгт нилээд хэдэн эерэг болон сөрөг талууд байна.

Сөрөг талууд:

1. Улаанчулуутын хогийн цэг нь Улаанбаатарын баруун хойд зүгт салхирхаг газар байрладаг тул хогийн цэг дээрх хог салхинд хийсэх өндөр магадлалтай.
2. Сонгинохайрхан дүүргийн гэр хорооллын зах өргөсснөөр гэр хорооллын хэсэг хогийн цэгрүү нилээд ойртох асуудал үүсээд байна.

Эерэг талууд:

Улаанчулуутын хогийн цэгийг сайжруулах туршилтын төсөл хэрэгжүүлснээр байгаль орчинд үзүүлэх бохирдол, тоос, гал гарсны улмаас үүсэх утаа зэрэг нь нилээд хэмжээгээр багасна ингэснээр өөрөөр хэлбэл Улаанчулуутын хогийн цэг дээр туршилтын төсөл хэрэгжүүлснээр Нарангийн Энгэрийн хог цэгт нилээд хэдэн давуутай талууд үүсч байна. Нарангийн Энгэрийн хогийн цэг нь цахилгаан эх үүсгүүрийг ойроос авч хэрэглэн, Улаанчулуутын хогийн цэгээс Нарангийн Энгэрийн хогийн цэг хүртэл хатуу хучилттай зам тавина гэсэн нөхцлүүдийг харгалзаж үзэхэд 5 шалгуурын хамгийн сайн нь байгаа бөгөөд эдгээр нөхцлүүд нь бусад боломжит газруудыг бодвол нөхцлөөр хамаагүй сайн байна. Мөн түүнчлэн, энэ хэсэгт Ландфил бүхий хогийн эцсийн цэг байгуулвал эдийн засгийн үр ашиг сайтай байна. Харин Цагаандаваагийн хогийн цэгийн хувьд салхины доод талд байрладаг. Цагаандаваагийн хогийн цэг нь зүүн дүүргүүдэд ойрхон түүнээс гадна хог тээвэрлэх зардал хямд иймд, эдгээр боломжит газруудын ерөнхий нөхцөл байдлын үзүүлэлтэд бид хамгийн өндөр буюу (0) оноо өгч байна. Бохирдолын үзүүлэлтийн хувьд (2) оноо нийгмийн нөхцөл байдлын хувьд (0) оноо өгч байна.

Мориндаваагийн хогийн цэг нь Олон Улсын Нисэх Онгоцны буудалтай нилээд ойрхон оршдог тул тус хогийн цэг дээрх хог салхинд хийсэн онгоцны буудлын ойр хавийн орчныг бохирдуулах өндөр магадлалтай тул хогийн цэгийн ерөнхий нөхцөл байдлын үзүүлэлтэд (5) оноо өгч байна. Цаашилбал, дүүргүүдээс хогийн цэг хүртэлх хог тээвэрлэх зай хол тул (5) оноо өгөв. Харин бохирдолын үзүүлэлтийн хувьд, бид (3) оноо өгч байна.

Багануурт хогийн эцсийн цэг байгуулах асуудал бүр ч боломжгүй учир нь Монгол Улсын хуулиар уурхайн эзэмшил талбайд хогийн цэг байгуулахыг хориглоно гэсэн заалт байдаг. Мөн түүнчлэн Улаанбаатар хотын дүүргүүдээс Багануур хүртэл хог тээвэрлэх зай нилээд хол нэмж хэлэхэд, энэ хогийн цэг дээр хог ачиж авчиртал шат дамжлага ихтэй. Багануурын нүүрсний уурхай энэ хэсэгт байрладаг тул гүний усыг бохирдуулах магадлал ихтэй. Иймд эдгээр нөхцлүүдийг харгалзан Багануурын хогийн цэгт (5) оноо өгч байна.

Баянгийн Хонхорын хогийн цэгийн хувьд, энэ тухай бодох ч хэрэггүй болов уу. Морирдаваагийн хогийн цэг ч мөн адил. Харин Цагаандаваагийн хогийн цэгийн хувьд нөхцөл байдал нь жаахан хүндрэлтэй. Бидний үзэж байгаагаар, ХМК-ийн ашиглах хугацаа богино боловч зардал багатай байна. ХМК-ийн хувьд ашиглах хугацаа нь л бага боловч өөр асуудалгүй хэрэв ийм асуудалгүй л бол ХМК-ийн хувьд оновчтой боломжит газруудын нэг нь байж болох юм. Бид ХМК-ийг өөр нэг боломжит газартай хамтран цуг ашиглаж болох юм.

Бид Нарангийн Энгэр, Цагаандаваагийн хогийн цэгийг хамгийн оновчтой хувилбар хэмээн үзэж байна. Иймд, эдгээр 2 боломжит газрыг хогийн эцсийн цэг байгуулахад оновчтой хувилбар хэмээн үзэж Удирдах Зөвлөлийн хуралд хэлэлцүүлэхээр санал болгож байна.

А.6.3 Үнэлгээний хуудсан дээр бичиж өгсөн оролцогчдын санал бодол

С. Мягмаржав: Зохион байгуулалтыг ийм (энэ удаагийнх шиг) маягаар явуулах. Дараагийн зөвлөгөөнөөр хүнд хортой хог хаягдлын менежментийн судалгааны асуудлаар хийх.

Ц. Юра: Бүх гарсан асуудалтай санал нэг байна.

Ч. Оюунбаатар: Хойшид хэлэлцэх асуудлаар ярьсан хүмүүс санал бодлоо давтахгүй байх! Тогтсон хогийн цэгт Засгийн газрын хөтөлбөрийн дагуу ногоон хэрэм хөтөлбөрийг хэрэгжүүлэх санаатай байна.

П. Ганбаатар: Зохих түвшинд шаардлагын хэмжээнд зохион байгуулж явуулаа гэж үзэж байна.

Н. Оюунцэцэг: Дийлэнхи оролцогчид хог хаягдлын менежментийн талаар ойлголт муу учраас асуулт хариултад их цаг зарцуулагдаж байна.

Ц. Болд: Одоогийн явуулж буй арга хэлбэр таалагдаж байна.

Ш. Дагва: Зохих түвшинд, шаардлагын хэмжээнд зохион байгуулаж байна гэж үзэж байна.

Б. Оюун: Судалгааны ажлын талаар, туршилтын ажил хийгдсэний дараа дараагийн бага хурлыг зохион байгуулах нь зүйтэй байна.

Д. Сүхбат: Энэ удаагийн бага хурал зохион байгуулалттай сайн болсон.

Б. Наран: Өнөөдөр зохион байгуулсан бага хурал шиг байхад боломжтой.

М. Золжаргал: WWF, Туул-21 төслөөс зохих хүмүүсийг оролцуулах, тухайлбал: Туул-21 үйлдвэрүүдийн хаягдалд үнэлгээ хийсэн туршлагатай.

Л. Баатарцогт: Гол хэлэлцэх сэдвээсээ их хальж байна. Тухайлбал, боломжит 6 цэг дээр ярьж 1 цэгийг сонгох асуудлыг зөвхөн ярих ёстой байтал хогийн цэгийн үйл ажиллагааны технологи руу хэт орж цаг их алдсан семинар боллоо.

Ц. Нүүдэл: Энэ зөвлөгөө маш үр дүнтэй.

Балгансүрэн: Тодорхой үр дүн рүү чиглүүлсэн өрөөсгөл мэдээлэл өгч байгаа мэт сэтгэгдэл ьөрлөө. Үйлдвэрийн хогны асуудлыг хор нөлөөтэй хогийн асуудлаар хаасан харамсалтай байна. Барилгын хогийг тооцохгүйгээр УБ хотын хогийн асуудлыг авч үзэх нь өрөөсгөл байх болно. 2008 он хүртэл (хогийн цэгийг нээх хүртэл) ХМКХЦ-г ашиглах нь 1) зардал багатай 2) нөхөн сэргэлт хийж эдэлбэр газар бий болгох зэрэг ач холбогдолтой байх мэт.

Ц. Цэнгэл: 1. Хогийн цэг байгуулах газар дээр нь очиж үзэх ажлыг зохион байгуулах 2. Төслийн ажлын талаар сурталчилгаа (хэвлэл мэдээлэл) тогтмол явуулах 3. Ажлын техникийн комиссын гишүүдийг сургалт болон туршлага судлуулах (Япон, Хятад оронд).

Содномпил: Ард иргэдийн дунд хог хаягдлын тухай ойлголт бий болгох, ялангуяа, Японы талаас хийж буй энэ сайхан ажлын талаар эерэг, зөв ойлголт өгөх үүднээс иргэдийн төлөөлөгчдийг энэ хуралд оролцуулах нь зүйтэй болвуу. Сурталчилгааны ажлыг сайн явуулж иргэдэд тодорхой мэдлэг олгох хэрэгтэй байна.

Д. Ганболд: 1. Нарангийн энгэрийн хогийн цэгийн төсөл хэрэгжүүлэхээс өмнө СХД, 4-р хороотой хамтарсан уулзалт, зөвлөгөөн зохион байгуулах 2. Дараагийн бага хурлыг төсөл хэрэгжүүлснээс (3-6) сарын дараа 3. Хог тээвэрлэлтийн

явцад өртөх дүүрэг, хороодын орчны бохирдолтыг багасгах, цэвэрлэхэд төслөөс зохих хувиар хамруулах.

Д. Батдорж: Өртөг зардлыг бодолцож 2 цэгийг зэрэг ашиглахаар сонгох саналтай.

З. Эрдэнэхүү: Бага хурал болж харилцан ярилцаж нийгэмд нөлөөлөх нөлөөллөөр ярилцах нь зүйтэй байх.

Ш. Ванганжил: 1-р бага хуралд ороогүй, 2-р бага хуралд оруулсанд баярлалаа, хамгийн гол нь бид хог хаягдлын төлөө тэмцдэг тул дараагийн бага хуралд ормоор байна.

Н. Шижирбаатар: Дараагийн бага хурлыг хэрхэн зохион байгуулахад энэ бага хурал шиг хийх хэрэгтэй байна.

Хавсралт 7: Оролцогчдын үнэлгээ

ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Нэр.....

Албан тушаал.....

Харилцах утас

Дараах 1-5 гэсэн оноогоор үнэлгээ өгнө үү:

- 1 = муу
- 2 = сайн биш
- 3 = дунд
- 4 = сайн
- 5 = онц

A. Бага хурал Танд хэрэг болсон уу?

1 2 3 4 5

B. Бага хурал нь оролцогсодын дунд тулгамдаж буй асуудлууд болон хамтран ажиллах шаардлагын тухай нийтлэг ойлголтыг дээшлүүлж чадсан гэж үзэж байна уу?.....

1 2 3 4 5

C. Бага хурал хатуу хог хаягдлын судалгааны үйл ажиллагаанд тусламж дэмжлэг болов уу?

1 2 3 4 5

D. Бага хурлын үйл ажиллагааны явц үр ашигтай, сонирхолтой байсан уу?

1 2 3 4 5

E. Бага хурлын үйл ажиллагаанд ерөнхий дүгнэлт өгнө үү?

1 2 3 4 5

Судалгааны багийн бүрэлдэхүүнд дараагийн Бага хурлыг хэрхэн зохион байгуулах, хэлэлцэх асуудал болон бусад асуудлаар санал, зөвлөмжөө бичнэ Үү.....

.....
.....
.....

ОРОЛЦОГЧДЫН НЭГТГЭСЭН ҮНЭЛГЭЭ

А. Бага хурал танд хэрэг болсон уу?

	1	2	3	4	5	Нийт
Дүн	0	0	1	10	26	37
%-иар	0%	0%	3%	27%	70%	100%
Дундаж дүн -			94%			
		4.7				

В. Бага хурал нь оролцогсодын дунд тулгамдаж буй асуудлууд болон хамтран ажиллах шаардлагын тухай нийтлэг ойлголтыг дээшлүүлж чадсан гэж үзэж байна уу?

	1	2	3	4	5	Нийт
Дүн	0	0	0	13	24	37
%-иар	0%	0%	0%	0%	35%	100%
Дундаж дүн -			93%			
		4.6				

С. Бага хурал хатуу хог хаягдлын судалгааны үйл ажиллагаанд тусламж дэмжлэг болов уу?

	1	2	3	4	5	Нийт
Дүн	0	1	1	7	28	37
%-иар	0%	3%	3%	19%	76%	100%
Дундаж дүн -			94%			
		4.7				

Д. Бага хурлын үйл ажиллагааны явц үр ашигтай, сонирхолтой байсан уу?

	1	2	3	4	5	Нийт
Дүн	0	0	1	9	27	37
%-иар	0%	0%	3%	24%	73%	100%
Дундаж дүн -			94%			
		4.7				

Е. Бага хурлын үйл ажиллагаанд ерөнхий дүгнэлт өгнө үү?

	1	2	3	4	5	Нийт
Дүн	0	0	1	107	26	37
%-иар	0%	0%	3%	27%	70%	100%
Дундаж дүн -			94%			
		4.7				

Дүгнэлт

Хамгийн ихээр өгөгдсөн оноо нь онц байсан бөгөөд нийт дүнгийн : 70%, 65%, 76%, 73%, 70% эзлэв.

Эхний дөрвөн асуултын дундаж оноо 5-аас 4.7, сүүлийн асуултын дундаж оноо 4.6 байв.

Дундаж оноог хувиар бодвол 94% мөн 93% болов.

4.2.3 Гуравдугаар бага хурал

МОНГОЛ УЛСЫН УЛААНБААТАР ХОТЫН ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ СУДАЛГАА

3 ДУГААР БАГА ХУРЛЫН ТАЙЛАН

2005 оны 10 дугаар сар

Агуулга:

1	Оршил	4-109
2	Зорилго	4-109
3	Хурал зохион байгуулах болон төслүүдийн явцыг дүгнэх аргачлал	4-109
3.1	Хурлын оролцогчид.....	4-109
3.2	Бага хурлын процедур	4-110
3.3	Үнэлгээ өгөх аргачлал	4-110
4	Бага хурлын зохион байгуулалт	4-110
4.1	Хорооны иргэдийн хурал	4-110
4.2	Хогийн цэг дээр ажиллдаг хог түүгч нар оролцсон хурал	4-111
5	Хурлын үр дүн	4-113
5.1	Хорооны оршин суугчидтай хийсэн хурал.....	4-113
5.2	Хогийн цэг дээрх хурал (Хог түүгчид оролцов)	4-115
6	Дүгнэлтүүд	4-116
6.1	Хорооны оршин суугчидын хурал	4-116
6.2	Хогийн цэг дээрх хурал (Хог түүгчид оролцсон)	4-117

Хүснэгт:

Хүснэгт 1: Хорооны иргэдийн хурлын процедур	4-111
Хүснэгт 2: Хогийн цэг дээр ажилладаг хог түүгч нар оролцсон хурлын процедур.....	4-112
Хүснэгт 3: Оролцогсодыг нас хүйсээр ангилбал	4-113
Хүснэгт 4: Оролцогсодыг нас хүйсээр ангилбал	4-115

Хавсралт:

Хавсралт 1: Хуралд оролцогч нарын нэрсийн жагсаалт.....	4-118
Хавсралт 2: Хөтөлбөр	4-119
Хавсралт 3: Хогийн төвлөрсөн цэгийн үйл ажиллагааг хянах үнэлгээний хуудас.....	4-120

1 Оршил

ЖАЙКА-ийн судалгааны төсөл хэрэгжүүлж эхэлсэнээс хойш 2004 оны 12 дугаар сар ба 2005 оны 4 дүгээр сард нийт хоёр бага хурлыг зохион байгуулаад байна.

Анхны Бага хурлын зорилго:

- Тулгарч буй асуудлууд ба туршлага хуваалцах;
- Нэгдсэн ойлголттой болох ба салбар доторх бусад асуудлуудыг хооронд нь холбох;
- Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын асуудлыг сайжруулахад хамтран ажиллах хэлбэрээр зөвшилцөл бий болгох ажлыг эхлүүлэх.

Хоёрдугаар Бага хурлын зорилго:

- Хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах Мастер төлөвлөгөө боловсруулахад ирээдүйн хогийн төвлөрсөн цэг байгуулах байршлыг тогтоох шаардлагын талаар нэгдсэн ойлголттой болох;
- Ирээдүйн хогийн төвлөрсөн цэг байгуулах боломжит 6 газрын хатуу хог хаягдлын менежментийн техникийн системийн хувилбаруудын эерэг болон сөрөг талуудыг судалж ярилцах;
- Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийн ирээдүйн хогийн төвлөрсөн цэг байгуулах байршлын талаар зөвлөмж гаргах.

Туршилтын төслүүдийн явцыг дүгнэх зорилгоор 10 дугаар сарын 18-нд Гуравдугаар Бага хурлыг зохион байгуулсан. Зарим нэг төслүүд нь зөвхөн хэрэгжиж эхлэх шатандаа явж байсан тул Сонгинохайрхан дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэр дээр хэрэгжиж буй “Улаанчулуутын хогийн төвлөрсөн цэгийн нөхцлийг яаралтай сайжруулах” болон “Хог хаягдлын асуудлаар иргэдийн мэдлэг ухамсарыг дээшлүүлэх” гэсэн хоёр төслийг үнэлгээ дүгнэлт өгөх ажилд сонгож авсан.

Эхний хоёр бага хуралд Техникийн ажлын хэсгийн гишүүд болон хамтран ажилладаг байгуулагуудын төлөөгч оролцдог байсан бол энэ удаа, гуравдугаар Бага хурлын үйл ажиллагаанд туршилтын төслийн явцыг үнэлэх, дүгнэх ажлыг 4 дүгээр хорооны иргэд болон Улаанчулуутын хогийн төвлөрсөн цэг дээр ажилладаг хог түүгч нар оролцов.

2 Зорилго

3 дугаар Бага хурлын гол зорилго нь Сонгинохайрхан дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хэрэгжиж буй дарах хоёр төслүүдийн явцыг тухайн хорооны иргэд болон хог түүгч нараар дүгнүүлэхэд оршиж байв.

- Улаанчулуутын хогийн төвлөрсөн цэгийн нөхцлийг яаралтай сайжруулах
- Хог хаягдлын асуудлаар иргэдийн мэдлэг ухамсарыг дээшлүүлэх,

Бага хурлын дүн дээр үндэслэн шаардлагатай гэж үзвэл туршилтын төслүүдийн төлөвлөлтийг өөрчлөх болно.

3 Хурал зохион байгуулах болон төслүүдийн явцыг дүгнэх аргачлал

3.1 Хурлын оролцогчид

3 дугаар Бага хурлын үйл ажиллагаанд орон нутгийн төлөөлөл буюу хорооны иргэд болон хог түүгч нарыг оролцуулах зорилттой байсан.

Хогийн цэг дээр хог түүж буй хог түүгч нарын ихэнх нь 4 дүгээр хорооны иргэд байсан боловч дээрх хоёр төслийг үнэлэхэд хорооны иргэд болон хог түүгч нарын дүгнэлт өөр байх болов уу гэж таамаглаж байв. Түүнчлэн хорооны иргэдийн зүгээс хог түүгч нарыг айлган сүрдүүлэх явдал гарахыг үгүйсгэхгүй тул хурлыг хоёр хэсэгт хувааж (1) хогийн цэг дээр ажилдаггүй 4 дүгээр хорооны иргэдийн дунд болон (2) хогийн цэг дээр ажиллаж буй хог түүгч дунд гэж тус тусад нь дараах байдлаар зохион байгуулав.

- Хэсэг 1: Хорооны иргэдийн хурал
- Хэсэг 2: Хогийн цэг дээр ажиллаж буй хог түүгч нарын хурал

Хорооны иргэдийн хурал нь дээр дурьдсан хоёр туршилтын төслийн явцыг дүгнэсэн бол хог түүгч нарын хурлаар зөвхөн Улаанчулуутын хогийн төвлөрсөн цэгийн нөхцлийг яаралтай сайжруулах төслийг явцад үнэлгээ өгөв.

Судалгааны багийн зүгээс зар, сурталчилгааны материал бэлтгэж хорооны иргэдэд тараах замаар хуралд иргэдийг оролцохыг урсан бөгөөд 4 дүгээр хорооны ЗДТГ-аас төслийг олон нийтэд танилцуулах уулзалтанд оролцож хогийн төвлөрсөн цэгийн анхны буюу туршилтын төсөл хэрэгжихээс өмнөх байдалтай танилцаж байсан 20 төлөөлөгч нарыг урив. Түүнчлэн оролцох хүсэлт гаргасан хүмүүсийг хурлын арга хэмжээнд идэвхтэй оролцохыг уриалсан.

Хог түүгч нарын хурлын хувьд оролцох хүмүүст хогийн цэгийн зохицуулагч урилга тарааж гэр бүл болгоноос нэг төлөөлөгч оролцохыг хүссэн.

3.2 Бага хурлын процедур

Хурлын эхэнд үнэлгээ өгөх ажлын өмнө тухайн туршилтын төслийн талаар танилцуулга хийсэн бөгөөд хорооны иргэдийн хурлын үеэр бодит байдалтай танилцуулах, илүү их ойлголт өгөх зорилгоор хогийн төвлөрсөн цэг болон хог хаягдлыг хууль бусаар хаясан цэгүүд дээр газар дээр нь үзүүлэх ажлыг зохион байгуулсан.

3.3 Үнэлгээ өгөх аргачлал

Судалгааны багийн бэлтгэсэн асуулгын маягыг бөглөх хэлбэртэй үнэлгээг явуулсан бөгөөд энэхүү хэлбэрийг юуны түрүүнд оролцогч нарын тоо их, түүнчлэн, монголчууд бусдын өмнө өөрийн үзэл бодлоо тэр болгон чөлөөтэй илэрхийлдэггүй байдлыг харгалзан үзэж багийн журмаар хэлэлцүүлэг явуулах аргачлалыг ашиглаагүй болно.

4 Бага хурлын зохион байгуулалт

Гуравдугаар Бага хурлыг 2 хэсэгт хуваан зохион байгуулсан: (1) Хорооны иргэдийн уулзалт болон (2) Хог түүгч нарын уулзалт. Хурлын тухай мэдээллийг доор хураангуйлав.

4.1 Хорооны иргэдийн хурал

(1) Үнэлгээ өгөх туршилтын төслүүд

Дээр дурьдсаны дагуу 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хэрэгжиж буй хоёр туршилтын төслийг үнэлгээ өгөх ажилд сонгон авсан.

- Улаанчулуутын хогийн төвлөрсөн цэгийн нөхцлийг яаралтай сайжруулах
 - Хог хаягдлын асуудлаар иргэдийн мэдлэг ухамсарыг дээшлүүлэх
- (2) Үнэлгээний ажилд хамруулах оршин суугчид

- Хогийн цэг дээр ажилдаггүй тухайн хорооны иргэд: нэгдүүгээр үнэлгээний ажилд оролцож байсан иргэдийг оролцуулан нийт 50 хүнийг урив

(3) Хурлын процедур

Хурлын үйл ажиллагааг гурван хэсэгт хуваасан: (1) Туршилтын төслүүдийн тухай танилцуулга (лекци хэлбэрээр хийх), (2) хогийн цэг дээр очих, болон (3) Үнэлгээний ажил (туршилтын төслүүдийн явцыг үнэлэх).

Хурлын ихэнх оролцогчид сүүлийн хэдэн саруудад хогийн цэг дээр очих боломж гараагүй тул тэдгээр оролцогч нарт газар дээр нь очиж танилцах боломжийг олгов. Хогийн төвлөрсөн цэгтэй газар дээр нь очиж танилцах үер байнгын хяналт хийдэг үнэлгээний хуудсыг оролцогч нараар бөглүүлэв (Хавсралт 2 үзнэ үү). Тэрхүү үнэлгээний дүнг “Улаанчулуутын хогийн төвлөрсөн цэгийн нөхцлийг яаралтай сайжруулах” төслийг олон нийтэд танилцуулах хоёрдугаар уулзалтын үер хэлэлцэж дүгнэсэн болно.

Үнэлгээний ажлын хүрээнд оролцогч нарыг дараах асуултанд хариулахыг хүсэв.

1) “Улаанчулуутын хогийн төвлөрсөн цэгийн нөхцлийг яаралтай сайжруулах” төслийн үнэлгээ

- Байгаль орчны нөхцөл байдал өөрчлөгдсөн эсэх (Туршилтын төсөл хэрэгжүүлснээр ямарваа нэгэн өөрчлөлт орсон уу? Өөрчлөлт орсон бол сайжирсан, сайжраагүй эсвэл дордсон зүйлүүдийг нэрлэх?)
- Бусад нэмэх санал

2) “Хог хаягдлын асуудлаар иргэдийн мэдлэг ухамсарыг дээшлүүлэх” төслийн үнэлгээ

- Иргэдийн дунд мэдлэг ухамсар нь өөрчлөгдсөн эсэх (туршилтын төсөл хэрэгжүүлснээр таны мэдлэг ухамсар өөрчлөгдсөн үү? Өөрчлөгдсөн бол ямар зүйлүүд сайжирсан, ямар өөрчлөлтүүд орсон бэ?)
- Сургалт сурталчилгааны материалын ач холбогдол, тэдгээрийн үр дүн (тараасан материал болон самбарын талаарх таны санал, зөвлөмж)
- Хог хаягдлын асуудлаар иргэд хүмүүсийн байдал, хэв маягт өөрчлөлт орсон эсэх (таны байдал, амьдралын хэв маягт өөрчлөлт орсон уу?)

Хурлын процедурыг Хүснэгт 1 үзүүлэв.

Хүснэгт 1: Хорооны иргэдийн хурлын процедур

Хэсэг I: Туршилтын төслийг танилцуулах
Нээлтийн үг
Хурлын зорилго
Туршилтын төсөл: Улаанчулуутын хогийн төвлөрсөн цэгийн нөхцлийг сайжруулах
Туршилтын төсөл: Хог хаягдлын асуудлаар нийтийн мэдлэг ухамсарыг дээшлүүлэх
Газар дээр нь очиж танилцах хөтөлбөр болон үнэлгээний хуудсыг хэрхэн бөглөхийг тайлбарлах
Хэсэг II: Газар дээр нь очиж танилцах
Хогийн цэг болон 4 дүгээр хорооны нутаг дэвсгэр дээр байгаа зарим хууль бус хогийн цэгийн байдалтай газар дээр нь очиж танилцах
Хэсэг III: Үнэлгээ
Үнэлгээ хэрхэн хийх талаар танилцуулах
Үнэлгээ өгөх
Үнэлгээний дүгнэлт
Хаалтын үг

4.2 Хогийн цэг дээр ажилладаг хог түүгч нар оролцсон хурал

(1) Үнэлгээ өгөх туршилтын төсөл

- Улаанчулуутын хогийн төвлөрсөн цэгийн нөхцлийг яаралтай сайжруулах
- (2) Үнэлгээний ажилд хамруулах хүмүүс
- Хурлын үйл ажиллагаанд оролцох сонирхолтой бүх хог түүгч нар: нэг гэр бүлээс нэг хүнийг төлөөлүүлж урив
- (3) Хурлын процедур

Хурлын үйл ажиллагааг хоёр хэсэгт хуваасан: (1) Туршилтын төслүүдийн тухай танилцуулга, (2) Үнэлгээний ажил.

Үнэлгээний ажлын хүрээнд оролцогч нарыг дараах асуултанд хариулахыг хүсэв.

- Байгаль орчны нөхцөл байдал өөрчлөгдсөн эсэх (Туршилтын төсөл хэрэгжүүлснээр ямарваа нэгэн өөрчлөлт орсон уу? Өөрчлөлт орсон бол сайжирсан, сайжраагүй эсвэл дордсон зүйлүүдийг нэрлэх?)
- Ажлын байрны нөхцөл сайжирсан эсэх (Туршилтын төсөл хэрэгжүүлснээр ямарваа нэгэн өөрчлөлт орсон уу? Өөрчлөлт орсон бол сайжирсан, сайжраагүй эсвэл дордсон зүйлүүдийг нэрлэх?)
- Бусад нэмэх санал

Зарим оролцогч нар өөрсдийн саналаа бичгээр өгөх боломжгүй тохиолдолд тэдгээр хүмүүсийн санал хүсэлтийг авахын тулд дараах арга хэмжээг авсан.

- 1) Хоёр өөр өнгийн цаасан хуудас урьдчилан бэлтгэсэн.
- 2) Байгаль орчин/ажлын нөхцөл байдал сайжирсан эсэх асуултанд сайжирсан гэж хариулах тохиолдолд шар хуудсыг сонгож юу сайжирсан талаар хуудсан дээр нь саналаа бичих бөгөөд байдал бүр дордсон гэж үзвэл ногоон цаасыг сонгож саналаа бичих хэлбэрээр зохион байгуулсан.
- 3) Хэрвээ тухайн оролцогч нь ямар асуудал нь сайжирсан гэдэгийг оноож хэлэх боломжгүй тохиолдолд тодорхой газрын зураг дээр тухайн сонголт хийсэн өнгөт хуудсыг тогтох замаар туршилтын төслийн явцыг сайн эсвэл муу гэж дүгнэх боломжтой болсон.

Түүнчлэн зарим хог түүгч нарын бие барьсан байдлыг арилгах, чөлөөтэй уур амьсгал бий болгох зорилгоор тоглоом тоглох буюу оролцогч нарын идэвхийг дэмжих арга хэмжээг үнэлгээний ажлын өмнө авсан.

Хогийн цэг дээр ажилладаг хог түүгч нар оролцсон хурлын процедурын дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 2: Хогийн цэг дээр ажилладаг хог түүгч нар оролцсон хурлын процедур

Хэсэг I: Туршилтын төслийг танилцуулах	
	Нээлтийн үг
	Хурлын зорилго
	Туршилтын төсөл: Улаанчулуутын хогийн төвлөрсөн цэгийн нөхцлийг сайжруулах <ul style="list-style-type: none">◆ Барилга байгууламжийг сайжруулах◆ Үйл ажиллагааг сайжруулах (цаашид эрүүл ахуйн шаардлага хангасан ландфилыг хэрхэн хийх болон дэлгэрэнгүй төлөвлөгөөтэй танилцуулах)
Хэсэг II: Үнэлгээ	
	Үнэлгээ хэрхэн хийх талаар танилцуулах
	Тоглоом тоглох буюу оролцогч нарын идэвхийг дэмжих үйл ажиллагаа
	Үнэлгээ өгөх
	Үнэлгээний дүгнэлт

5 Хурлын үр дүн

5.1 Хорооны оршин суугчидтай хийсэн хурал

Сонгино хайрхан дүүргийн 4-р хорооны оршин суугчидтай хийсэн уулзалт нь тус хорооны хурлын танхимд 10 сарын 18-ний өглөө зохион байгуулагдсан юм.

5.1.1 Оролцогчид

Энэ хуралд оролцсон хүмүүсийн тоо 55 байсан бөгөөд нас, хүйсээр нь доор хүснэгтэд ангилав. Хяналтын комиссийн гишүүн, тус хорооны эрүүл мэндийн ажилтан нэг хүн энэ хуралд мөн оролцов. Тиймээс оролцсон хүний тоо нийтдээ 56 байсан бөгөөд оролцсон бүх хүмүүс асуултуудад хариулаагүй болно.

Хүснэгт 3: Оролцогсодыг нас хүйсээр ангилбал

Насны групп	эм	эр	нийт
20-29	8		8
30-39	7	3	10
40-49	8	2	10
50-59	5	3	8
60-69	11		11
70-79	6	1	7
80-89	1		1
нийт	46	9	55

5.1.2 Үнэлгээний үр дүн

Дараах асуултуудад иргэдийн өгсөн хариултыг нэгтгэж доор тавив.

A1: Хүрээлэн байгаа орчинд өөрчлөлт гарсан уу? Тийм бол ямар ямар эерэг болон сөрөг өөрчлөлтүүд гарсан бэ?

A2: Хог хаягдлын талаар хүмүүсийн ухамсарт өөрчлөлт гарсан уу? Тийм бол ямар ямар эерэг болон сөрөг өөрчлөлтүүд гарсан бэ?

A3: Иргэдийн дундах хог хаягдлаа хаях байдалд өөрчлөлт гарсан уу?

A4: Бидний тараасан сурталчилгааны материал болон зарлалын самбарын тухай юу бодож байна?

- A5: Нэмэх зүйлс

(1) A1: Хүрээлэн байгаа орчинд өөрчлөлт гарсан уу?

Асуултад хариулсан нийт хүмүүсийн тоо 43, үүний дотор 39 хүн эерэг санал, 4 хүн сөрөг саналаа өгсөн байна.

Оролцсон хүмүүсийн үзэж байгаагаар дараах өөрчлөлтүүд гарсан байна.

Эерэг санал

Нийт хариулсан хүний тоо	39
Туршилтын төслөөр маш олон юм дээрдсэн бөгөөд байгаль орчны тал дээр мөн байдал сайжирсан.	18
Хогийн цэг дээр маш олон барилга байгууламж баригдсан нь маш сайн байна	11
Хууль бус хог хаялт болон тархсан хог хаягдал багассан байна.	9
Хогийг эрүүл мэндийн шаардлага хангасан аргаар булсан байна.	5
Гал болон муухай үнэр багассан байна	3
Бусад	2

*Зарим оролцогчид нэгээс илүү санал бичсэн байв.

Сөрөг санал

Нийт хариулсан хүний тоо	4
Хогийн цэг дээр маш олон хүүхдүүд ажиллаж байна	1
Тархсан гялгар уут багасаагүй байна мөн гал багасаагүй байна.	1
Хогийн цэг хүрэх замын тоосноос болоод эрүүл мэндээр хохирч байна	1
Туршилтын төсөл хог түүгчдийн ажиллах нөхцлийн муутгасан.	1

(2) А2 Хог хаягдлын талаар хүмүүсийн ухамсарт өөрчлөлт гарсан уу?

Энэ асуултад нийт 37 хүн хариулж хариултуудыг дор хураангуйлав.

	Тоо
Эерэг санал	
Туршилтын төслөөр маш олон зүйл хийгдсэнээс хүмүүсийн ухамсар дээшилсэн	21
Дундын санал	
Хүмүүсийн ухамсар дээшилсэн боловч бүх хүнийх дээшлээгүй	9
Сөрөг санал	
Хүмүүсийн ухамсар ер өөрчлөгдөөгүй	7

(3) А3 Иргэдийн дундах хог хаягдлаа хаях байдалд өөрчлөлт гарсан уу?

Тус асуултад 27 хүн хариулав.

	Тоо
Эерэг санал	
Маш олон юм сайжирсан байна	4
Хууль бус хог хаягдал багассан.	5
Сөрөг санал	
Юу ч өөрчлөгдөөгүй, юу ч сайжраагүй	16
Хүмүүс урьдын адил хууль бусаар хогоо хаясаар байна	7

(4) А4 Бидний тараасан сурталчилгааны материал болон зарлалын самбарын тухай юу бодож байна?

Тус асуултад нийт 43 хүн хариулав.

	Тоо
Маш сайн бөгөөд ойлгоход амархан байсан	25
Маш сайн байсан бөгөөд харин хүн болгонд тараагдаагүй	14
Илүү их юм тараах, олон хүнд хүргэх хэрэгтэй.	20
Сурталчилгааг олон нийтийн телевиз радиогоор цацах хэрэгтэй	3
Хог хаягдлын талаар олон төрлийн сургалт семинар хийх хэрэгтэй	7

(5) А5 Нэмэх зүйл

48 оролцогчид 2 туршилтын төслийн талаар ерөнхий дүгнэлтээ хэрхэн өгсөн байдлыг доор хураангуйлав.

	Тоо
Хог хураах цагийн хуваарь гаргаад зориулалтын машинаар тогтмол хурааж байх	13
Гудам дунд хог хаях тусгай сав тавих эсвэл хог хаях газрыг тогтоож өгөх	5
Хогийн цэг рүү хүрэх замыг сайжруулж хучилттай болгох	16
Хууль бусаар хог хаясан хүнд торгууль ноогдуулах	3
Гялгар уутыг багасгах тал дээр арга хэмжээ авах	13
Бусад	12

Бусад:

Хогны машины тоог нэмэх
Хогийн цэгт гялгар уут хийсэхээс хамгаалж зөөврийн хашаа олныг барих
Хогийн цэгт хяналт тавьж аюулгүй ажиллагааг сахих
Тусгай зориулалтын хогны машинаар хангах
Мод тарих зүлэгжүүлэх зэргээр ногоон бүс бий болгох
Их цэвэрлэгээний ажлыг ойр ойрхон зохион байгуулах
Хогны мөнгө хураах тогтолцоог замбраатай болгож хяналтын системтэй байх
1. Айл өрхүүдэд хогоо ангилж хаях шинэ сисметийг нэвтрүүлэх
2. Хогийн цэгээс нааш тархсан хогийг оршин суугчдаар цэвэрлүүлж цуглуулсан хогны хэмжээгээр нь хөлс өгөх
Хог түүгчидийн ажиллах нөхцлийг сайжруулах үүднээс ажлын хувцасаар хангах
1. Хог асгадаг жалга хонхор газрыг хогоор дүүргэж хөрсөөр хучин битүүлэх
2. Гялгар уутны хэрэглээг багасгах шинэ санаа сэдэх
Хогийн цэгт хяналт тавьж аюулгүй ажиллагааг сахих
Айл өрхүүдэд хогоо ангилж хаях шинэ сисметийг нэвтрүүлэх

5.2 Хогийн цэг дээрх хурал (Хог түүгчид оролцов)

Хогийн цэг дээр ажилладаг иргэдтэй хийсэн хурал нь 10 сарын 18-нд хогийн цэгийн дулаан гражинд хорооны иргэдийн хурлын дараа зохион байгуулагдав.

5.2.1 Оролцогчид

Нийтдээ 81 хүн (хүүхдүүдийг оролцуулан) оролцсоныг нас хүйсээр нь дор ангилав.

Хүснэгт 4: Оролцогсодыг нас хүйсээр ангилбал

Нас	эм	эр	Нийт
10-19	4	3	7
20-29	3	5	8
30-39	16	8	24
40-49	18	11	29
50-59	3	8	11
60-69		2	2
Нийт	44	37	81

5.2.2 Хурлын үр дүн

Хурал дээр дараах асуултуудыг оролцогсодоос асуув.

A1: Хүрээлэн байгаа орчинд өөрчлөлт гарсан уу? Тийм бол ямар ямар эерэг болон сөрөг өөрчлөлтүүд гарсан бэ?

- A2: Ажиллаж буй нөхцөлд чинь ямар нэгэн өөрчлөлт гарсан уу? Тийм бол ямар ямар эерэг болон сөрөг өөрчлөлтүүд гарсан бэ?
- A3: Нэмэх зүйл

Хариултуудыг доор нэгтгэв.

(1) A1: Хүрээлэн байгаа орчинд өөрчлөлт гарсан уу?

Энэ асуултад хуралд оролцсон бүх хүн хариулсан бөгөөд туршилтын төсөл эерэг өөрчлөлтийг гаргасан гэсэн хариулт өгсөн хүмүүс шар хуудсан дээр сөрөг нөлөө гаргасан гэсэн хүмүүс ногоон хуудсан дээр хариултаа бичиж өгсөн юм.

Шар хуудсан дээр хариултаа бичсэн хүний тоо 74 байсан бөгөөд тэдний 52 нь ямар өөрчлөлтүүд гарсаныг бичсэн байна (зарим хүн нэгээс их санал бичсэн). 7 хүн ногоон цаас сонгосон бөгөөд тэдний 6 нь гарсан сөрөг нөлөөг бичсэн байна.

Эерэг санал

Нийт хариулсан хүний тоо	74
Байгаль орчинд нөлөөлөх маш олон эерэг өөрчлөлтүүд гарсан	56
Агаарын бохирдол багассан нь бидний эрүүл мэндэд тустай	6
Муухай үнэр багассан	8
Барилга байгууламж баригдсан мөн хог тархах нь багассан	4
Хогийн цэг дээрх гал болон утаа униар багассан	9

Сөрөг санал

Нийт хариулсан хүний тоо	7
Үйл ажиллагаа нь хангалттай бус	1
Агаарын бохирдорлын асуудал байсаар байна	4
Хогийн цэг дээр маш олон хүүхэд ажиллаж байна	1
Худалдан авагчид маань бидний түүсэн бүтээгдэхүүнийг дутуу жинлэх, хямдханаар худалдаж авах явдал гардаг	1

(2) A2: Ажиллаж буй нөхцөлд чинь ямар нэгэн өөрчлөлт гарсан уу?

Энэ асуултанд хуралд оролцсон хүний тэн хагасаас бага тооны буюу 37 хүн хариулт өгсөн бөгөөд 27 нь эерэг, 10 хүн сөрөг хариулт өгсөн байна.

Эерэг санал

Нийт хариулсан хүний тоо	27
Ажиллах нөхцөл сайжирсан	13
Эрүүл ахуйн байдал сайжирсан, энэ нь бидний эрүүл мэндэд тустай	6
Арай дэг журамтай эмх цэгцтэй болсон	6
Бусад Бидний саналыг сонсож байгаад баяртай байна Биднийг бүртгэж авсанаар бидний энд ажиллах урам зориг нэмэгдсэн	4

Сөрөг санал

Нийт хариулсан хүний тоо	10
Ажиллах нөхцөл сайжраагүй	3
Телевизийн сурвалжлагч нар бидэнтэй уулзаад цааш нь буруу мэдээлэл цацсан	4
Худалдан авагчид бидний түүхий эдийг хямдханаар худалдан авдаг	4
Хог түүгч нарыг бүртгэж эхэлснээр маш олон шинэ хүмүүс ирж ажиллах болсон	1

(3) АЗ: Нэмэх зүйл

Нийт 53 хүн асуултад хариулж төслийн талаархи ерөнхий саналаа өгөв.

	нийт
Ажлын хувцасаар хангах	7
Нийтийн халуун усны газар нийтийн жорлон болон цайны газартай болох	11
Хогны машин дээр авирч гардаг хүүхдүүдийг авирдагыг нь болиулах	9
Хогийн цэг дээр бидний түүхий эдийг авдаг тогтсон хүн байвал сайн байна	8
Бидний тухай буруу мэдээлэл хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлээр тараадаг явдлыг зогсоох	3
Хог түүгчидийн бүртгэлийг үргэжлүүлж шинээр ирэгсэгдийг бүртгэх	3
Одоогийн байдлаар маш бага талбайд олон хог түүгчид ажиллаж байгаа нь хүндрэлтэй байгаа учир талбайг томосгох хэрэгтэй байна	8
Микро автобусны үйлчилгээ болон эмнэлгийн үйлчилгээ хэрэгтэй байдаг	4
Бусад	11

Бусад

Хогийг тэгшлэж түрэх ажиллагааг өглөө эрт эхлүүлж харин хогийн машин их ирдэг оргил үед завсарлаж хог ухах боломж олгох
Одоогийн байгаагаас илүү ихийг сайжруулах
Хогийн ангилах ялгах хэрэгтэй
Илүү ихийг хийх хэрэгтэй
Аюулгүй ажиллагааг хангах нь чухал
Хогийн цэгийг эмх цэгцтэй байлгахын тулд дурэм журам бий болгох
Хогийн цэг дээр ажиллаж байгаа техникийн бүрэн бүтэн байдлыг хангах
Хүрээлэн буй орчныг илүү цэвэрхэн байлгах
Хогийн цэг дээр жижиглэнгийн худалдаа явуулах
Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах нөхцлийг бий болгох

6 Дүгнэлтүүд

6.1 Хорооны оршин суугчидын хурал

(1) Улаанчулуутын хогийн төвлөрсөн цэгийн нөхцөлийг яаралтай сайжруулах

Ерөнхийдөө, хуралд оролцогсод туршилтын төслийг эерэгээр хүлээж авсан байсан хэдий ч зарим хүмүүс уг төслийн утга санааг буруугаар ойлгосон нь харагдаж байв. Туршилтын төсөл дөнгөж эхэлээд хогийн цэгийн үйл ажиллагаа жигдэрч амжаагүй байсан ч ихэнх хүмүүс эрүүл ахуйн шаардлага хангасан ландфилын үйл ажиллагааг эхэлжээ гэж тооцов.

Хороодын оршин суугчид хогийн цэгийг маш ихээр сайжрахыг хүлээж байгаа учир дараагийн хавраас хүчтэй салхи дэгдэн хог хаягдлыг хийсгэхээс өмнө хотын захиргаа нь судалгааны багтай хамтран цэгийн үйл ажиллагааг жигдрүүлсэн байх нь чухал юм.

(2) Хог хаягдалын асуудлаар нийтийн мэдлэг ухамсарыг дээшлүүлэх

Энэ төсөл нь тус хорооны зарим иргэдэд маш ихээр нөлөөлсөн бөгөөд манай судалгааны баг эдгээр хүмүүсийг ирээдүйд хог хаягдлын тал дээр ихээхэн үүрэг гүйцэтгэх байх гэж найдаж байгаа билээ.

Үүнээс гадна, дараагийн үе шат болох хог хаягдлыг хаях журам гэх мэт олон нийтийг оролцуулсан үйл ажиллагаан дээр ажиллаж эхэлэх хэрэгтэй. Гэтэл хог хаях шинэ дүрэм журмыг хогийн үйлчилгээг сайжруулж тогтмол цуглуулдаг болохоос нааш иргэдэд танилцуулж хэрэгжүүлэх нь бүтэлгүй асуудал болох юм. Мастер төлөвлөгөөнд тусгасны дагуу хамгийн түрүүнд орон сууцны хорооны хог цуглуулах үйлчилгээг сайжруулна. Энэ нь ТҮК-үүдийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлж улмаар гэр хороонд хүргэдэг үйлчилгээг сайжруулахад нэмэр болно. Тэгэхээр үүнээс харахад гэр хороонд шинээр хог хаях дүрэм журам хэрэгжтэл хэдэн жил болно.

Сургалт сурталчилгааны материалууд нь иргэдээс ерөнхийдөө сайн үнэлгээ авч байгаа нь энэхүү ЖАЙКА-гийн төсөл хэрэгжихээс өмнө иргэдэд ямар нэгэн мэдээлэл хүрдэггүй байсантай холбоотой байж болно. Тиймээс хотын захиргаа нь Улаанбаатар хотын бүх хороодод энэ тал дээр олон нийтийн арга хэмжээнүүд зохиосоор байх нь чухал.

6.2 Хогийн цэг дээрх хурал (Хог түүгчид оролцсон)

Хамгийн эхний асуулт болох байгаль орчны асуултанд хуралд оролцогсод бүгдээрээ хариулт өгсөн нь тэдний энэ сэдэвт сонирхолоо ихээр хандуулж байгааг харуулж байна. Тэдний ихэнх нь туршилтын төсөл байгаль орчинд эерэгээр нөлөөлж байгаад баяртай байгаагаа илэрхийлсэн.

Гэтэл хоёрдугаар асуултанд хариулсан хүний тоо нийт оролцогчдын тэн хагасаас бага байсан бөгөөд хариулсан 37 хүний ихэнх нь ажлын нөхцөл сайжирсан гэж хариулсан боловч хариу өгөхөөс татгалзсан хүмүүс туршилтын төслийн улмаас тэдний ажиллах нөхцөл муудсан гэж бодсон байх магадлалтай.

Ландфилын ажиллагаа эхэлэхэд хогны машинууд зөвхөн заасан газарт хогоо асгах бөгөөд энэ нь хог түүх талбайг багасгах юм. Үүнээс болоод туршилтын төсөлд олон хог түүгчид сэтгэл хангалуун бус байх нь ойлгомжтой юм.

Энэ дэг журамтай ландфилын үйл ажиллагаа нь энэ төслийн гол утга санаа болохоор энэ тал дээр тэдэнтэй санал нийлж болохгүй юм. Түүний оронд тэдэнтэй зөвшилцөлд хүрэхийн тулд эрүүл ахуйн тал дээр болон түүхий эдийн цуглуулалт, худалдааг шударга болгох тал дээр арга хэмжээ авах нь зүйтэй юм.

Хавсралт 1: Хуралд оролцогч нарын нэрсийн жагсаалт

(1) Хорооны оршин суугчидтай хийсэн хурал

Хорооны иргэд нараас бусад оролцогсод

Нэр	Байгууллага	Албан тушаал
Ч.Батсайхан	НЗДТГ	Стратегийн бодолго, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
Б.Дэлгэрбаяр	Захирагчийн ажлын алба	Хот тохижилтын хэлтсийн мэргэжилтэн
Ч.Гончигсумлаа	Байгаль орчны яам	Стратеги төлөвлөлт, бодлого зохицуулалтын газрын орлогч дарга
Энхжаргал	4 дүгээр хороо	Өрхийн эмнэлгийн ажилтан
Б.Төгөлдөр	ЖАЙКА	Төлөөлөгчийн газрын жилтан
Ж.Жамбалдорж	Нөөц компани	Захирал
Энхээ	ТББ-Дэлхийн зөн	
Баатаржав	ТББ-Байгаль эрдэнэ сан	
Чулуундолгор	ТББ- "Толгойт"	
К.Кани	ЖАЙКА судалгааны баг	Мэргэжилтэн
О. Туул	Хурал удирдагч	

(2) Хогийн төвлөрсөн цэг дээр хийсэн хурал

Хог түүгч нараас бусад оролцогсод

Нэр	Байгууллага	Албан тушаал
Ж.Жамбалдорж	Нөөц компани	Захирал
С.Шимура	ЖАЙКА судалгааны баг	Ахлагч
К.Кани	ЖАЙКА судалгааны баг	
Хара	ЖАЙКА сайн дурын зөвлөх	
О. Туул	Хурал удирдагч	

Хавсралт 2: Хөтөлбөр

Он, сар, өдөр: 2005 оны 10 дугаар сарын 18

(1) Хорооны оршин суугчидтай хийсэн хурал

Хурал Сонгинохайрхан дүүргийн 4 дүгээр хорооны хурлын танхимд болов.

	Цаг	Сэдэв	
1	9:45 – 10:00	Бүртгэл	
Хэсэг I: Туршилтын төслийг танилцуулах			
	10:00 – 10:05	Нээлтийн үг	Д.Ганболд, Засаг дарга, 4р хороо
	10:05 – 10:10	Хурлын зорилго	О.Туул (хурлын дарга)
	10:10 – 10:20	Туршилтын төсөл: Улаанчулуутын хогийн төвлөрсөн цэгийн нөхцлийг сайжруулах	Ж.Жамбалдорж Нөөц компани
	10:20 – 10:30	Туршилтын төсөл: Хог хаягдалын асуудлаар нийтийн мэдлэг ухамсарыг дээшлүүлэх	Б.Дэлгэрбаяр, ЗАА
	10:30 – 10:35	Үзэж танилцах газрын тухай болон шалгах хуудсыг хэрхэн бөглөхийг тайлбарлах	Б.Дэлгэрбаяр, ЗАА
Хэсэг II: Очиж танилцах			
	10:35 – 11:30	Хогийн цэг болон 4р хороон дээрх хууль бусаар хог хаяагддаг газарт очих	Ж.Жамбалдорж Нөөц компани
Хэсэг III: Үнэлгээ			
7	11:30 – 11:35	Үнэлгээ хэрхэн хийх талаар танилцуулах	О.Туул
8	11:35 – 12: 30	Үнэлгээ өгөх	О.Туул
9	12:30 – 12:40	Үнэлгээний дүгнэлт	О.Туул
10	12:40 – 12:45	Хаалтын үг	

(2) Хогийн цэг дээр ажилладаг хог түүгч нар оролцсон хурал

Хурлын газар: Хогийн цэг дээрх дулаан гараж

	Цаг	Сэдэв	
1	3:15 – 3:30	Бүртгэл	
Хэсэг I: Туршилтын төслийг танилцуулах			
2	3:30 – 3:35	Нээлтийн үг	Ж.Жамбалдорж Нөөц компани
3	3:35 -3:40	Хурлын зорилго	О.Туул
4	3:40 – 4:00	Туршилтын төсөл: Улаанчулуутын хогийн төвлөрсөн цэгийн нөхцлийг сайжруулах ◆ Бариалга байгууламжийг сайжруулах ◆ Үйл ажиллагааг сайжруулах (цаашид эрүүл ахуйн шаардлага хангасан ландфилог хэрхэн хийх болон дэлгэрэнгүй төлөвлөгөөтэй танилцуулах)	Ж.Жамбалдорж Нөөц компани
Хэсэг II: Үнэлгээ			
5	4:00 – 4:05	Үнэлгээ хэрхэн хийх талаар танилцуулах	О.Туул (хурлын дарга)
6	4:05 – 4:20	Тоглоом тоглох буюу оролцогч нарын идэвхийг дэмжих үйл ажиллагаа	О.Туул
7	4:20 – 5:10	Үнэлгээ өгөх	О.Туул
8	5:10 – 5:15	Үнэлгээний дүгнэлт	О.Туул

Хавсралт 3: Хогийн төвлөрсөн цэгийн үйл ажиллагааг хянах үнэлгээний хуудас

Үнэлгээний хуудас		Он, сар, өдөр				
		Нэр				
		Байгууллагын нэр				
А ангилал: Байгаль орчны асуудлууд ба үйл ажиллагааны нөхцөл (барилгын ажлын өмнө ба хойно)						
Байгаль орчны асуудлууд						
No	Зүйл	Зөвшөөрхүйц	Дунд зэрэг	Маш муу	Дүн	Тайлбар
A1	Гал ба утаа	0	1	2		
A2	Эвгүй үнэр	0	1	2		
A3	Хаягдал ус	0	1	2		
A4	Хог хаягдлын тархалт	0	1	2		
A5	Амьтан (нохой, шувуу, зэрэг)	0	1	2		
A6	Шавьж (ялаа, өт, зэрэг)	0	1	2		
A7	Гадна байдал	0	1	2		
Үйл ажиллагааны нөхцөл (Диспетчер ландфилын үйл ажиллагааг нийтэд нь хянаж байгаа байдал)						
No	Зүйл	Сайн хяналт- тай эсвэл ажиллагаатай	Дунд зэрэг	Маш муу	Дүн	Тайлбар
A8	Нийт үйл ажиллагаа	0	1	2		
A9	Хог түүгч нарын ажлын нөхцөл	0	1	2		
A10	Хогны машин	0	1	2		
A11	Бульдозер болон бусад ландфилын ажиллагааг хангах хүнд даацын машин механизм	0	1	2		
A12	Хог хаягдал буулгах байршил	0	1	2		
A13	Халдваргүйжүүлэх ажил хийгдсэн эсэх	0	1	2		
А ангилал, Нийт дүн						
В ангилал: Хогийн цэгийн байгууламжуудын үйл ажиллагаа (барилгын ажлууд дууссаны дараа хийх үнэлгээ)						
No	Зүйл	Ажиллагаатай	Дунд зэрэг	Ажиллагаагүй	Дүн	Тайлбар
B1	Нэвтрэх зам	0	1	2		
B2	Автопүү	0	1	2		
B3	Хогийн цэг доторх зам	0	1	2		
B4	Ажлын талбар (хөдөлгөөнт хашаа зэрэг)	0	1	2		
B5	Хий зайлуулах байгууламж	0	1	2		
B6	Хамгаалалтын байгууламж Хашаа (хөдөлгөөнгүй), хаалга, далан	0	1	2		
B7	Бохир шингэн цэвэрлэх байгууламж	0	1	2		
B8	Муу усны систем	0	1	2		
В ангилал, Нийт дүн						
Санал						

4.2.4 Дөрөвдүгээр бага хурал

МОНГОЛ УЛС УЛААНБААТАР ХОТЫН ХАТУУ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ СУДАЛГАА

ДӨРӨВДҮГЭЭР БАГА ХУРАЛЫН ТАЙЛАН

2006 оны 5 дугаар сар

Агуулга:

1	Бага хурлын тухай.....	4-123
1.1	Огноо ба хурал зохион байгуулсан газар	4-123
1.2	Оролцогчид	4-123
1.3	Хөтөлбөр.....	4-123
2	Асуулт, хариулт	4-123

1 Бага хурлын тухай

RDF түлшийг нүүрстэй хольж шатаах анхны туршилтын дүнг нийтэд танилцуулах зорилгоор 4 дүгээр Бага хурлыг зохион байгуулав. Бага хурлыг дараах байдалтай зохион байгуулав.

1.1 Огноо ба хурал зохион байгуулсан газар

Огноо: 2006 оны 5 дугаар сарын 17 (Лха)
Газар: ЗАА-ны 8 дугаар давхар, Хурлын танхим
Хугацаа: 10:00 - 13:00

1.2 Оролцогчид

Дараах байгууллагуудын төлөөлөгчдыг оролцуулахаар урив. Үүнд:

- Түлш, эрчим хүчний яам
- Байгаль орчны яам
- Мэргэжлийн хяналтын газар
- УБ хотын захиргаа
- Техникийн ажлын хэсгийн гишүүд
- Налайхын дулааны станц
- ТББ-ын төлөөлөгчид
- Хэвлэл мэдээлэл

1.3 Хөтөлбөр

Сэдэв	Илтгэгч	Цаг
• Бүртгэл		10:00 – 10:30
• Нээлтийн үг	ЗАА	10:30 – 10:40
• RDF үйлдвэрлэл болон шатаах туршилтын тухай видео үзүүлэх	ЖАЙКА СБ	10:40 – 10:50 (10 минут)
• RDF түлшийг нүүрстэй хольж шатаах анхны туршилтын дүн	Б.Дэлгэрбаяр, ЗАА М.Сарнтуяа, БОЯ	10:50 – 11:50 (нэг цаг)
• Цайн завсарлага		11:50 – 12:00
• Асуулт, хариулт	ЗАА, ЖАЙКА СБ	12:00 – 12:40 (40 минут)
• Цаашид хийгдэх ажлуудын төлөвлөгөөний талаар танилцуулж хаалтын үг хэлэх	ЗАА	12:40 – 12:50

2 Асуулт, хариулт

Бага хурлын асуулт, хариултын тэмдэглэлийг доор үзүүлэв.

A1: 4 дүгээр цахилгаан станц дээр энэ түлшийг шатааж болохгүй байгаа шалтгаан?

X1: Дэлгэрбаяр (ЗАА):

Зуухны төрлөөс хамаарч байгаа юм. Энэ түлшийг Багануур болон Налайхын дулааны станц, 3 дугаар цахилгаан станцт хэрэглэж болно. Харин 4 дүгээр цахилгаан станцын стандарт нь өөр учраас хэрэглэж болохгүй.

Q2: Бум-Ялагч (Монголын ногоон нам):

Би жилийн өмнө болж байсан төслийн ажлыг олон нийтэд танилцуулах анхны хурлын үер асууж байсан асуултаа дахиад тавих гэсэн юм. Тухайн үед надад хариулт өгнө гэж байсан ч би одоо болтол хангалттай хариулт аваагүй байгаа.

Манайх Японы нэг хүрээлэнтэй хамтарч ажилладаг юм. Энэ RDF түлш уг нь Германы технологи боловч Япончууд энэ технологийг ашиглаж байгаа. Аюулгүй байдлын үүднээс ямар байдаг юм болоо? Японы RDF түлшний үйлдвэрт 6 осол гарсан гэж би сонссон. Түлшийг хадгалж байх үед өөрөө шатаж улмаар үйлдвэрт нь дэлбэрэлт болсон гэсэн. Үүнээс болоод зарим үйлдвэрийн үйл ажиллагаа зогсож хаагдсан гэсэн. Харин танай мэргэжилтнүүд энэ түлшийг ямарч аюулгүй гэж байгаа. Хэрэв Японд гарсан шиг хадгалж байх процест Монголын нөхцөлд өөрөө шатах тохиолдол гарвал яах вэ?

A2: Шимура (Судалгааны багийн удирдагч):

Маш зөв чухал асуулт тавьсан байна. Тиймээ, Японы үйлдвэрт таны хэлсэн шиг осол гарсан нь үнэн. Ийм осол гарсан шалтгаан бол тухайн үйлдвэрүүд нь RDF түлшнийхээ бүтцийн агуулганд хүнсний хаягдал оруулах болсон юм. Хүнсний хог хаягдал агаарын хангамжгүй орчинд ялзрах үедээ Японы чийглэг уур амьсгалтай газар метан хий ихээр ялгаруулдаг. Улмаар ялгарсан хий нь дэлбэрч гал гарсан. Бид энэ байдлыг харгалзан үзэж, урьдчилан сэргийлэн RDF түлшээ зөвхөн гялгар уут болон цаасаар хийхээр төлөвлөж байна. Японы тэрхүү туршлага дээр үндэслэн бид RDF-ийн бүтцэнд нь ямар ч хүнсний хог хаягдал оруулахгүйгээр аюулгүй байдлыг хангаж осол гарахгүй болно.

A3: Пүрэвцэнд (Эвт чулуу ХХК):

ЖАЙКА байгууллага буцалтгүй тусламжаа энэ төслийнхөө хүрээнд л өгч байгаа юмуу? Эсвэл хог хаягдлыг дахин боловсруулан ашиглах хувийн аж ахуйн нэгжид ч гэсэн хөрөнгө оруулалт хийх юм уу?

X3: Дэлгэрбаяр:

Манай төсөл 2004 оны 12 дугаар сараас эхэлсэн бөгөөд 2020 он хүртэл байгаль орчинд хэрхэн хор хөнөөлгүй, аюулгүй байдлаар хог хаягдлын асуудлыг шийдэх талаар анхаарч ажиллаж байгаа.Та сая ядуурлыг бууруулах болон хог хаягдлыг багасгах талаар ямар арга хэмжээ авч байна вэ гэлээ. Одоогийн ашиглаж байгаа УЧХЦ-ийн ашиглалтын хугацаа удахгүй дуусах болохоор бид Нарангийн энгэр гэдэг газар шинэ хогийн цэг байгуулна. Тэнд Рисайкл цогцолбор болон RDF түлшний үйлдвэр байгуулна. Ус, цахилгаан, дулааныг татаж дэд бүтэцтэй болгоно. Мөн хог хаягдлыг дахин боловсруулах аж ахуйн нэгжид тэндээ газар өгч хувийн хэвшлийн байгууллагыг урин ажиллуулж үйл ажиллагааг нь дэмжинэ. Шинэ хогийн цэг дээр хог хаягдал ялгах цогцолборт иргэд ажиллах боломжтой болно.

A4: Бум-Ялагч:

1 шуудай RDF түлш хэдэн төгрөгөөр үйлдвэрлэгдэж байна вэ?

X4: Дэлгэрбаяр:

1 тонн RDF түлш 9 долларын¹ өртөгөөр гарсан. 1 тонн нүүрс 13 доллар байгаа.

A4: Бум-Ялагч:

Тэгэхээр нүүрснээс бага өртөгөөр гарч байна. Дээр нь илчлэг чанар сайтай учраас хувь хүмүүс гэрийнхээ зууханд түлэх гээд байх юм биш үү?

X4: Дэлгэрбаяр:

Бид нар үйлдвэрлээд шууд шатаа ДЦС руу нийлүүлнэ.

A4: Бум-Ялагч:

Гэхдээ үүнийг үйлдвэрлэж байгаа явцыг харж байхад үйлдвэрлэх арга нь маш энгийн, гар аргаар үйлдвэрлэх боломжтой болохоор хувь хүмүүс өөрсдөө хууль бусаар үйлдвэрлээд байвал яах вэ?

X4: Дэлгэрбаяр:

Бид үүнийг шууд хориглоно. Энэ талаар бид нар арга хэмжээ тухайн үед нь авах болно.

A5: Дагва (Түлш эрчим хүчний яам):

Сарантуяагаас асуух юм байна. Шаталтаас ялгарах хийн стандартыг өөр улсын стандарттай харьцуулах боломжгүй гэлээ. Тиймээс Японы стандарттай л харьцуулсан гэсэн. Би андуураагүй бол манайх Стокгольмийн конвенцийн гишүүн улс. Тэр конвенцэд олон улсын стандарт бичигдсэн байдаг. Тэдгээртэй харьцуулаагүй юм уу?

X4: Сарантуяа (Байгаль орчны яам):

Тийм. Бид өөр улсуудын стандарттай харьцуулаагүй. Судалгааны багийнхан өөрсдийн гэсэн стандарттай учраас Японыхоо стандарттай харьцуулсан. => Судалгааны баг Стокгольмийн конвенцийн тухай материал болон Европын холбооны стандарттай харьцуулах хүснэгт бэлтгэв.

A5: Дагва:

Тэд нар өөрсдийнхөө стандарттай харьцуулсан ч та нар БОЯ өөрсдөө тусдаа тэр олон улсуудын стандарттай харьцуулж болоогүй юмуу?

X4: Сарантуяа:

Бидэнд харьцуулах цаг байсангүй. Бид энэ шинжилгээний үр дүнтэй өнгөрсөн Баасан гаригт танилцсан. Тиймээс үүнийг өөрсдөө харьцуулан шинжлэх цаг байсангүй.

A5: Жаргалсайхан (Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга):

Надад хэд хэдэн сануулж хэлэх зүйл байна. Бид нар энэ төслийг эхлэж байхаас нь авхуулаад Налайхын дулааны станц дээр хийсэн туршилт хийх хүртэл холбогдох арга хэмжээнд оролцож, төслийн явцыг анхааралтай ажиглаж байгаа.

1: RDF түлш үйлдвэрлэсэн гол хэрэглээ юу вэ гэдгийн юуны түрүүнд сайн ойлгох хэрэгтэй. Бид энэ түлшийг хольж шатааснаараа гол нь нүүрсний илчлэгийг л нэмэх зорилготой. Бид нар саяхан 1,8 мегаватын хүчин чадалтай, 4000 ккал нүүрс шатаах

¹ 9 ам.доллар нь RDF түлш худалдах орлогын үнийн дүн бөгөөд үйлдвэрлэлийн үнэ 27 ам.доллар. Хурлын илтгэлийн 17 дугаар слайд үзнэ үү.

зориулалтын Багахангай дулааны станцын үйл ажиллагааг эхлүүлсэн. Гэвч шатах чанарын хүчин чадал нь хүрэлцэхгүй байна. RDF бол нүүрсний илчлэг чанарыг нэмэгдүүлэхийн тулд хийгдсэн. Түүнээс биш үүнийг хамаагүй дэвэргэж өөр талын асуудал уруу ормооргүй байна. Жишээ нь сая ярилаа: 4 дүгээр цахилгаан станцын стандарт тохирохгүй учраас энэ түлшийг шатааж болохгүй, хэрэв технологийг нь өөрчилвөл шатааж болно гэж. Би энд нэг юм хэлмээр байна: гол зорилгынхоо дагуу л яваачээ гэж. Та бүхэн мэдэж байгаа манай дулааны цахилгаан станцууд бүгд нүүрс түлэх зориулалттай. Тиймээс энд дулаан цахилгаан станцын технологийг өөрчлөх тухай ямар нэгэн яриа гарахгүй байвал зүгээр байна.

2: Ялгарч байгаа хийн дүн шинжилгээн дээр хэлэхэд харьцуулалтууд буруу байна. Нүүрстэй л харьцуулах ёстой. Би зарим нэг тоон дээр эмзэглэж байна. Жишээ нь 0,08 байснаас 0,11 болж ихэссэн байхад (бараг 30%-иар) Сарантуяа үүнийг бараг өөрчлөлтгүй, хэвийн хэмжээтэй адилхан байна гэж ярьж байгаа нь маш буруу. Тэгэхээр хувиар өсөөд байгааг анхаарч үзэх хэрэгтэй. Байгаль орчны яам үүнийг өөрчлөлт байхгүй гэж үзэж болохгүй. Диоксин өчүүхэн бага хувиар өсөхөд л аюултай шүү дээ.

3: Дараагийн туршилтандаа ямар байгууллагаас ямар мэргэжлийнхэнийг оролцуулан хамтарч ажиллахаа бас бодолцмоор байна. Жишээ нь дулааны инженерүүдийг оролцуулах хэрэгтэй. Одоо 3200 илчлэгтэй байгаа нүүрсийг 4000-4200 ккал болгож нэмэх талаар бодох хэрэгтэй.

4: Түүрэн 15 тонн нүүрсийг RDF-тэй хольсоноор 8 тонн болгож нүүрсний хэмжээг багасгасан гэж ярилаа. Ингэж нүүрсний хэмжээгээ багасгаж байгаа нь эдийн засгийн талаасаа сайн байна. Гэхдээ үүнийг дагаад хорт бодисын хэмжээ нэмэгдэх эсэх, мөн байгаль орчин болон хүмүүсийн эрүүл мэндэд хор учруулах эсэхийг бодолцоорой.

А6: Нарантуяа (Нийтийн эрүүл мэндийн хүрээлэнгийн захирал):

Энэ туршилтын ажилд агаарын бохирдол, эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэнүүд оролцсон уу? Дүн шинжилгээний хариунаас харж байхад энд стандартын хэмжээ нь Японы стандартаас ялигүй их байгаа ч манайхны стандартаас хэтрэхгүй байсан гэж ойлгож болох уу? RDF түлшийг 4%-иар нүүрстэй холиход ялгарах хийн хэмжээ 0.1-ээс бага байна гэдэг нь 4%-иар нүүрстэй холих үед диоксин хэмжээ бага учраас хор нөлөөгүй гэж ойлгож болох уу? Эдийн засгийн ач холбогдолын талаар гэвэл яагаад аж ахуйн нэгжүүдэд энэ түлш үйлдвэрлэлтийг санал болгоогүй вэ? гэж асуумаар байна.

Х6: Дэлгэрбаяр:

3 дугаар асуултнаас эхэлье. Аж ахуйн нэгж болгон энэ түлшийг үйлдвэрлэвэл сөрөг байдал үүснэ. Жишээ нь гэрийн зууханд түлж болохгүй энэ түлшийг олон айл ахуйн хэрэглээндээ ашиглах магадлалтай. Тиймээс бид энэхүү үйлдвэрлэлтээ Захирагчийн ажлын албаны доор хийж, үйлдвэрээс нь шууд станцт нийлүүлнэ. Та бүхэн түрүүн видео дээрээс энэ түлшийг гар аргаар үйлдвэрлэж буйг харсан. Харин буцалтгүй тусламжаар НЭРЦ байгуулагдахаар RDF түлш хийх зориулалтын техник технологитой болно. Энэ түлшийг үйлдвэрлэх нь гялгар уутнаас гарах хүндрэлийг багасгах юм.

1 дүгээр асуултын хариуг өгье. Бид мэргэжлийн хүмүүстэй хамтарч туршилтаа хийсэн. Мэдээж энд дутагдалтай талууд байгаа байх. Өнөөдрийн энэ хурлын гол зорилго бол дараагийн туршилтаа хийхдээ ямар хүмүүстэй хамтран ажиллах вэ, ямар зүйлийг анхаарах вэ, хэрхэн яаж нэмэгдэл зардлыг багасгах вэ гэх мэт зүйлүүдийг шийдэхийн тулд зохион байгуулагдсан бөгөөд та бүгдийн санал бодлыг сонсох зорилго агуулсан. Энэ түлш нь одоогийн байдлаар судалгааны шатандаа явж байна. Түүнээс биш яг ингээд тогтчихсон, өөрчлөхгүйгээр шийдчихсэн гэсэн үг биш юм шүү. Бид та нартай хойшдоо хэзээд ч хамтран ажиллахад бэлэн байна.

Жаргалсайхан гуайн хлорын хэмжээ ихэссэн тухай ярилаа. Энэ тал дээр тодруулж хэлэх юм гэвэл энэ бол судалгааны үе шатандаа явагдаж байна. Бид саяны дүн шинжилгээний үр дүн дээр үндэслээд Японы зуухнууд ямар шүүлтүүр хэрэглэж байна, манай зуухнуудад ямар шүүлтүүр суурьлуулах вэ гэдгийг анхаарч дараагийн арга хэмжээгээ авах болно.

A6: Сарангуяа:

Стандартын тухай нэмж хэлэхэд яг одоогоор манайд диоксины стандарт байхгүй, харин бусад хэмжилт хийсэн үзүүлэлтүүдийн стандарт бол манайд байдаг.

A7: Бум-ялагч:

Эрүүл мэндийн яамнаас гаргасан хогны бүтцийн судалгаа байдаг. Тэнд хүнсний хог хаягдалын хэмжээ өсөхгүй байгааг ард иргэдийн ядууралтай холбож тайлбарласан байсан. Тэгэхээр хүнсний хог хаягдал бага гарч байгаа нь үнэхээр хүмүүсийн амьжиргааны түвшнээс хамаарч байна уу?

X7: Болд (Хот тохижилт хэлтсийн дарга):

Өнгөрсөн жил эрүүл мэндийн яамнаас судалгаа хийсэн. Манай энэ судалгааны багийнхан ч бас өвөл зун 2 удаа судалгаа өөрсдөө хийсэн. Энэ судалгаануудаар хүнсний хог хаягдалын хэмжээ өсөх магадлал бараг байхгүй гэж гарсан. Хүмүүсийн яриаг сонсч байхад урд нь бол гахай нохойндоо өгөх хоол гэж Улаанбаатар, Баянгол ресторанаас хаягдал хүнс 20-30 литрээр нь өдөр болгон авдаг байсан бол одоо ерөөсөө олдохоо больсон гэсэн.

Шимура:

Монгол орны хог хаягдлын бүтцийг судалж үзэхэд ерөнхийдөө бусад орнуудын бүтэцтэй бараг адил байсан. Хаягдал цаас, хуванцар савны хог хаягдлын хэмжээ их байсан. Гэвч хүнсний хог хаягдлын хэмжээ хамаагүй бага байгаа юм. Хог хаягдлын бүтэц нь улс орны эдийн засаг болон бизнесийн үйл ажиллагаанаас ихээхэн хамаарч байдаг. Монгол улсын хүнсний хог хаягдлыг Япон улстай харьцуулвал мэдээж бага байх нь ойлгомжтой боловч бүтэц нь нэлээд ижилхэн хүнсний хог хаягдал бага, цаас/хуванцар хаягдлын хэмжээ их байна. Түүнчлэн, Улаанбаатар хот бол улсын нийслэл учраас энд үйлдвэрлэл, бизнесийн үйл ажиллагаа төвлөрдөг. Ирээдүйд бизнесийн үйл ажиллагаа нэмэгдэх болохоор цаас, гялгар уут зэрэг хог хаягдлын хэмжээ нэмэгдэж байх болно. Нөгөөтэйгүүр, Монголд ногоо, жимсний үйлдвэрлэлийн цар хүрээ бага, хэрэглээ нь ч бага байгаа нь нөлөөлж байна.

A8: Батсайхан (Байгаль орчны яам):

Энэ төсөл үр ашигтай төсөл байна. Хэдэн зүйл асууя.

1:Нүүрстэй RDF түлшийг холь шатаах нь станцтад үр ашигтай гарч байна. Өмнө нь ДЦС-ын мэргэжилтэнгүүд өөрсдөө ямар нэгэн аргаар нүүрсээ хэмнэх арга зам хайж байсан уу? Ингэж өмнө нь практикт хэрэглэж үзэж байсан уу эсвэл анхны удаа хийж байгаа юм уу?

2:Та нар түлшээ 2% болон 4%-иар нүүрстэй хольж шатаажээ. 5,6%-иар хольж туршиж үзсэн үү? Та нар хольж шатаах хамгийн тохиромжтой хэмжээг олсон уу?

3:RDF түлшний шаталтын илч ямар байх нь түүхий эдээсээ цаас гялгар уутны хольцны хэмжээнээсээ хамаарч байна уу? Та нар хамгийн тохиромжтой харьцааг олсон уу?

4:Нэг тонн RDFтүлшний үнийн тооцоог яаж бодож гаргасан бэ? Үүнд гялгар уутыг худалдаж авах өртөг гээд багтаж байгаа юу?

5:Бойлерийн үр ашгийн тооцоог хэрхэн яаж гаргасан бэ?

Х8: Дэлгэрбаяр:

1:Өмнө нь цахилгаан станцын мэргэжилтэнгүүд нүүрсний хэмжээг багасгах талаас арга хэмжээ авдаг эсэх талаар би хог хаягдлын мэргэжлийн хүн болохоор хариулж мэдэхгүй байна. Бид энд хог хаягдлыг яаж үр ашигтай ашиглаж, хог хаягдлаар хэрхэн түлш хийж, цахилгаан станцад хэрхэн үр өгөөжтэй болгох вэ гэдэг талаас нь анхаарсан.

2:Энэ хольж шатаах хувийг тооцохдоо бид цахилгаан станцын хүчин чадлыг харгалзаж тогтоосон юмаа. Урд нь бид 8,10%-иар хольж шатаана гэж төлөвлөж байсан боловч зуухны дотоод шаталтын хүчин чадал хүрэхгүй учраас 2,4%-иар хольсон. 5%,6%-иар хольж шатааж болно. Хамгийн гол нь Налайхын цахилгаан станцын тоног төхөөрөмжинд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй байх шаардлагыг хангах хэрэгтэй байсан. Япон, Германд бол RDF түлшийг дангаар нь шатаадаг. Учир нь зориулалтын техник төхөөрөмжинд хийсэн байдаг учраас хорт хий ялгардаггүй юм байна.

3:Мэдээж хольцоос хамаарч илчлэгийн хэмжээнд өөрчлөлт орно. Жишээ нь хуванцарын хэмжээг багасгаад цаасны хэмжээг ихэсгэхэд илчлэг буурч байсан.

4:Бид RDF түлшнийхээ түүхий эдийг иргэдээс худалдаж аваагүй. Хогийн цэг дээрээс үнэгүй авч хэрэглэсэн. Ер нь сайн чанарын уут (хөнгөн цагаан савны боодол баглааны зузаан гялгар уут) бол 50 төгрөг байдаг. Гэхдээ сүүлийн үед ийм сайн чанарын уут олдохгүй байгаа. Харин нимгэн 10, 20 төгрөгний уутнууд (жимс ногоо хийдэг нимгэн цэнхэр, цагаан уут) бол худалдаж авахгүй ашиглагдахгүй энд тэнд хог болж байсаар байна. Тэрийг л ашиглах хэрэгтэй байна. Цуглуулах байгууллага болох ТҮК-иуд болон дарж булах үйл ажиллагаа явуулж буй Нөөц компани байхад өөрсдийн үнэгүй байгаа зүйлээ ашиглаж аль болох бага өртөгөөр RDF түлш үйлдвэрлэхийг зорьж байна.

5: **Шимура:** *Бойлерын үр ашгийн тооцоог Шимура гуай слайд дээр тайлбарлав.*

Батсайхан : (нэмэлт тайлбар хийв)

Манай эрчим хүчний гол түлш бол нүүрс байгаа. Тэгэхээр нүүрснийхээ зардлыг багасгах асуудал бол чухал. Энэ RDF түлшийг хольж шатааснаар нүүрсний хэмжээг багасгаж байгаа нь урд байгаагүй шинэ санаа юм. Манай ДЦС нь нүүрс л шатаах зориулалттай болохоор өнөөг хүртэл арга хэмжээ аваагүй байсаар өдий хүрчээ гэснээр хурлын асуулт, хариултын цаг өндөрлөв.